



**ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР,
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ**

НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬ /ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА/-ЫН ТӨСЛИЙГ ОЛОН НИЙТЭЭР ХЭЛЭЛЦҮҮЛСЭН ТАЙЛАН

**Улаанбаатар хот
2026 он**

2026.04.30

“Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т “Халамжаас хөдөлмөрт шилжих бодлоготой уялдуулан хөдөлмөр эрхлэлт, нийгмийн үйлчилгээний эрх зүйн орчныг шинэчилж, ядуурлыг бууруулах бодлого баримтална, Төрөөс үзүүлж байгаа нийгмийн халамж, тусламж, үйлчилгээг зөвхөн зорилтот бүлэгт чиглүүлнэ, Улс төрийн амлалтаар өрх, иргэнд халамжийн нийтлэг мөнгөн шилжүүлэг олгохгүй байхаар нийгмийн хамгааллын эрх зүйн орчныг өөрчилнө.” гэж тус тус заасан.

Эдгээр бодлогын зорилттой уялдуулан Нийгмийн халамжийн тухай хуулийн төслийг боловсруулах Ажлын хэсгийг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Мөнхзул ахлан, дэд ажлын хэсэгт судлаач, багш, төрийн болон төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулан уг хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж байна. Уг Ажлын хэсэг Нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг эцэслэн боловсруулж, дараах байдлаар хэлэлцүүлээ. Үүнд:

- ✓ 2025.01.16-ны өдөр Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2024.11.27-ны өдрийн А/58 дугаар тушаалаар байгуулагдсан Ажлын хэсгийн гишүүдэд танилцуулан хэлэлцүүлээ.
- ✓ 2025.01.22-ны өдөр Нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах судалгааны дэд ажлын хэсгийн гишүүдэд танилцуулан хэлэлцүүлэв.
- ✓ 2025.01.29-ний өдөр Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагууд, тэдгээрийн төлөөлөл /цахимаар 96, танхимаар 16/-д танилцуулан хэлэлцүүлэв.
- ✓ 2025.01.29-ний өдөр аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтсийн Нийгмийн халамжийн хэлтэс, албадын дарга нар /30 хүн/-т цахимаар танилцуулан хэлэлцүүлэв.
- ✓ 2025 оны 02 дугаар сарын 04-ний өдөр Нийгмийн хамгааллын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг олон улсын байгууллагуудын төлөөлөл /25 хүн/-д танилцуулан хэлэлцүүлэв.
- ✓ 2025.02.05-07-ны өдрүүдэд ХХҮЕГ, аймаг, дүүргийн нийгмийн халамжийн байгууллагын мэргэжилтнүүдтэй хамтран Нийгмийн халамжийн хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд тусгах саналыг хэлэлцүүлэв.
- ✓ 2025.05.09-ний өдөр Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх, оролцоо, хамгааллын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн болон ТББ-ууд /ЭМЯ, НДЕГ, ХБХХЕГ, ХХҮЕГ, ТББ-ууд/-д танилцуулан санал авч, хэлэлцүүлээ.
- ✓ 2025.05.23-ны өдөр Нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг яамдын мэргэжилтнүүдэд танилцуулах, мэдээлэл өгөх, санал солилцох хэлэлцүүлгийг зохион байгууллаа.
- ✓ 2025.06.03-ны өдөр Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх, оролцоо, хамгааллын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг, төрийн бус байгууллага, холбоодод Нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг танилцуулан санал авч, хэлэлцүүлээ.

- ✓ 2026.03.10-ны өдөр Төрийн захиргааны төв байгууллага, агентлаг, төрийн болон орон нутгийн өмчийн байгууллагын дэргэдэх ахмадын хороо, зөвлөлийн удирдах ажилтнуудад Нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг танилцуулж, хуулийн төсөлд санал авах хэлэлцүүлэг зохион байгууллаа.
- ✓ 2026.03.12-ны өдөр Алдар цолтой ахмад настан болон Хөгжлийн бэрхшээлтэй ахмад настануудын төлөөлөлд Нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг танилцуулж, хуулийн төсөлд санал авах уулзалт зохион байгууллаа.
- ✓ 2026.04.30-ны өдөр төрийн байгууллага, олон улсын байгууллага, төрийн бус байгууллага, судлаачид, иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл зэрэг нийт 100 гаруй хүнд Нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг танилцуулж, санал авах хэлэлцүүлгийг зохион байгууллаа.


/Холбогдох зургийг хавсаргав./



Нийгмийн халамжийн тухай хуулийг боловсруулах судалгааны дэд ажлын хэсэг
2025.01.22



Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус
байгууллагуудад танхимаар, 2025.01.29



Аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар хэлтсийн Нийгмийн
халамжийн хэлтэс, албадын дарга нарт цахимаар, 2025.01.29

2025.03.25-27-ны өдрүүдэд Нийгмийн халамжийн тухай хуулийг боловсруулах техникийн хэсэг хэлэлцүүлгийн саналыг тусган хуулийн төслийг эцэслэн боловсруулав.



“НЭГ АСУУДАЛ, НЭГ ШИЙДЭЛ” хэлэлцүүлэг
2025.05.09





Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагуудын үндэсний холбоо, Хөгжлийн бэрхшээлтэй иргэд байгууллагуудын “Шүхэр” бодлогын нэгдсэн зөвлөл хамтран Нийгмийн халамжийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлтөд хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг


хангах асуудлыг тусгах зорилгоор төр болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн чиглэлээр ажилладаг төрийн бус байгууллагуудын 40 гаруй албан хаагч, мэргэжилтэн, иргэдийн хүрээнд зохион байгууллаа.



Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг, төрийн бус байгууллага, холбоод, 2025.06.03-ны өдөр

2026.03.10
Тусгаар
тогтнолын
ордон





Алдар цолтон ахмад настан болон Хөгжлийн бэрхшээлтэй ахмад настуудын төлөөлөлд Нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг танилцуулж, санал авах уулзалт зохион байгууллаа. 2026.03.12



Нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн нээлттэй хэлэлцүүлэг 2026.04.30



Санал авч байна 2025-04-16

НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛД САНАЛ АВЧ БАЙНА.

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор баталсан "Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн 2.1.3-т "Халамжаас хөдөлмөрт шилжих бодлоготой уялдуулан хөдөлмөр эрхлэлт, нийгмийн үйлчилгээний эрх зүйн орчныг шинэчилж, ядуурлыг бууруулах бодлого баримтална.", "Төрөөс үзүүлж байгаа нийгмийн халамж, тусламж, үйлчилгээг зөвхөн зорилтот бүлэгт чиглүүлнэ.", "Улс төрийн амлалтаар эрх, иргэнд халамжийн нийтлэг мөнгөн шилжүүлэг олгохгүй байхаар нийгмийн хамгааллын эрх зүйн орчныг өөрчилнэ." гэж тусгасан.

Эдгээр бодлогын зорилттой уялдуулан Нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулаа.

Энэхүү хуулиар амьжиргааны түвшин доогуур, эмзэг байдалд өртсөн эрх, иргэний амьжиргааг дэмжих, эрсдэлт нөхцөлөөс урьдчилан сэргийлэх, бие даан амьдрах чадавхыг нэмэгдүүлэхэд чиглэсэн нийгмийн халамжийн төрөл, хамрах хүрээг тогтоох, нийгмийн халамжийн байгууллагын тогтолцоо, чиг үүргийг тодорхойлохтой холбогдсон харилцааг зохицуулах юм.

Та бүхэн Нийгмийн халамжийн тухай хуулийн төсөлд саналаа тус яамны otgonbileg@mflsp.gov.mn эсхүл buyanjargal@mflsp.gov.mn цахим хаягаар ирүүлнэ үү.

Хавсралт хэсгээс хуулийн төсөл болон тус хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлэх хуулийн төслүүдийг бүрэн эхээр нь татаж авч танилцана уу.

Хавсралт файл

№	Гарчиг	Татах
1	Нийгмийн халамжийн тухай хуулийн төсөл	Татах
2	Хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлэх хуулийн төслүүд	Татах

2.Олон нийтээс санал авах зорилгоор тус яамны цахим хуудсанд 2025 оны 04 дүгээр сарын 16-ны өдөр Нийгмийн халамжийн тухай хуулийн төсөл, дагалдах хуулийн төслийг байршуулсан.

Түүнчлэн цахимаар, утсаар, биечлэн ирүүлсэн саналуудыг судлан үзэж хуулийн төсөлд тусгалаа.


НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН
ТӨСЛИЙН ТАЛААР ОЛОН НИЙТЭД ХҮРГЭСЭН МЭДЭЭЛЭЛ

2026.05.20

Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем /legalinfo.mn/

https://legalinfo.mn/mn/discussion?type=LIS_SAID

Нийтэлсэн: 2026-05-29



🏠 НҮҮР

ЭРХ ЗҮЙН АКТ ▾

МЭДЭЭ

Нүүр > [Хуулийн төсөлд санал өгөх](#)

хуулийн төсөл

Агуулга

- Төрөл сонгох -

- Төлөв сонгох - ▾

- Салбар нэгж сонгох - ▾

Эхлэх огноо

Санал авч байна Хууль зүйн үндэсний хүрээлэн

Үлдсэн: 12 хоног
Нийтэлсэн: 2026-05-29

НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ТУХАЙ

дэмжинэ

0.0%

дэмжихгүй

0.0%

👤 ДАГАСАН (0)

👁️ ҮЗСЭН (242)

👥+ САНАЛ (0)

Санал өгөх

БАЙГУУЛЛАГЫН ЦАХИМ ХУУДСАНД:


1. НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛД САНАЛ АВЧ БАЙНА.

Огноо: 2025-04-16

<https://mlsp.gov.mn/content/detail/3702>

Төрийн үйлчилгээ ▾ Авлигын эсрэг үйл ажиллагаа e-Zasag.mn 1212.MN

Нүүр / Хууль эрх зүй / Санал авч байна / Дэлгэрэнгүй



Санал авч байна 2025-04-16

НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛД САНАЛ АВЧ БАЙНА.

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор баталсан "Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн 2.1.3-т "Халамжаас хөдөлмөрт шилжих бодлоготой уялдуулан хөдөлмөр эрхлэлт, нийгмийн үйлчилгээний эрх зүйн орчныг шинэчилж, ядуурлыг бууруулах бодлого баримтална.", "Төрөөс үзүүлж байгаа нийгмийн халамж, тусламж, үйлчилгээг зөвхөн зорилтот бүлэгт чиглүүлнэ.", "Улс төрийн амлалтаар эрх, иргэнд халамжийн нийтлэг мөнгөн шилжүүлэг олгохгүй байхаар нийгмийн хамгааллын эрх зүйн орчныг өөрчилнэ." гэж тусгасан.

Эдгээр бодлогын зорилттой уялдуулан Нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсрууллаа.

Энэхүү хуулиар амьжиргааны түвшин доогуур, эмзэг байдалд өрсөн эрх, иргэний амьжиргааг дэмжих, эрсдэлт нөхцөлөөс урьдчилан сэргийлэх, бие даан амьдрах чадавхыг нэмэгдүүлэхэд чиглэсэн нийгмийн халамжийн төрөл, хамрах хүрээг тогтоох, нийгмийн халамжийн байгууллагын тогтолцоо, чиг үүргийг тодорхойлохтой холбогдсон харилцааг зохицуулах юм.

Та бүхэн Нийгмийн халамжийн тухай хуулийн төсөлд саналаа тус яамны otgonbileg@mlsp.gov.mn эхсүл buyanjargal@mlsp.gov.mn цахим хаягаар ирүүлнэ үү.

Хавсралт хэсгээс хуулийн төсөл болон тус хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлэх хуулийн төслүүдийг бүрэн эхээр нь татаж авч танилцана уу.

Хавсралт файл

№	Гарчиг	Татах
1	Нийгмийн халамжийн тухай хуулийн төсөл	Татах
2	Хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлэх хуулийн төслүүд	Татах
3	Нийгмийн халамжийн тухай хууль/шинэчилсэн найруулга/-ыг дагаж мөрдөж журмын тухай хуулийн төсөл	Татах

Хайх

Ангилал

- Ярилцлага
- Санал авч байна
- Тайлан мэдээ
- Мэдээ
- Авлигын эсрэг үйл ажиллагаа
- Хүний нөөцийн удирлага
- Түгээмэл асуулт, хариулт
- Аудитын дүгнэлт
- Хөдөлмөрийн хяналт
- Бодлогын баримт бичгийн хэрэгжилт
- Тайлан
- Бодлого, төлөвлөлт
- Төсөл, хөтөлбөр
- Хөдөлмөр эрхлэлтийн статистик мэдээлэл
- Статистик мэдээлэл
- Зар, мэдээ
- Хүний нөөц

2. Нийгмийн халамжийг дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай зорилтот хэсэгт чиглүүлнэ.

Огноо: 2026-05-20

<https://mlsp.gov.mn/content/detail/4083>



Нүүр Яамны тухай ▾ Бодлого, чиглэл ▾ Мэдээ, мэдээлэл ▾ Хууль эрх зүй ▾ Ил тод ▾ Шилэн данс ▾

Төрийн үйлчилгээ ▾ Авлигын эсрэг үйл ажиллагаа e-Zasag.mn 1212.MN

Нүүр / Мэдээ, мэдээлэл / Цаг үеийн мэдээ / Далгарангүй



Мэдээ 2026-05-20

Нийгмийн халамжийг дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай зорилтот хэсэгт чиглүүлнэ

Нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн дэмжиж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр боллоо.

Нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчилсэн найруулга 2012 онд батлагдсанаас хойш өөрчлөгдөөгүй юм.

Нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулахдаа санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлж, халамжийг нэн шаардлагатай зорилтот бүлэгт чиглүүлэх, ядуурлыг бууруулах, ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх, нийгмийн тэгш байдлыг хангах, салбар хоорондын уялдааг сайжруулахад анхаарлаа.

Хуулийн төсөлд дараах зохицуулалтыг тусгалаа:

- Нийгмийн халамжийн бодлогыг хүн амыг өсгөх, гэр бүлийн хөгжил, эх, хүүхдийг дэмжих бодлогоос зааглаж, төсөвлөж, хэрэгжүүлэх;
- Халамж нэн шаардлагатай зорилтот бүлгийг оновчтой тодорхойлж тэдэнд чиглүүлэх, тэднийг эдийн засаг, нийгмийн эрсдлээс хамгаалах, ядуурлыг бууруулах бодлоготой уялдуулах;
- Халамжийн үйлчилгээнд хамрагдах иргэнийг тодорхойлох явцыг авилга ашиг сонирхлоос ангид байлгах;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүний онцлог хэрэгцээнд суурилсан олон талт үйлчилгээг хүргэх;
- Халамжийн олон хөтөлбөрүүдийг нэгтгэх, багцлах, хэрэгцээнд нийцсэн оновчтой болгох;
- Хөдөлмөрийн насны, хөдөлмөрийн чадвартай иргэдийг халамжаас хараат бус байлгах, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээнд хамруулж тэдний амьжиргааг дэмжих, тогтмол орлоготой ажлын байртай болгох, бие даан

Хайх

Хайх түлхүүр үг оруулна уу...

Ангилал

- ☆ Ярилцлага
- ☆ Санал авч байна
- ☆ Тайлан мэдээ
- ☆ Мэдээ
- ☆ Авлигын эсрэг үйл ажиллагаа
- ☆ Хүний нөөцийн удирлага
- ☆ Түгээмэл асуулт, хариулт
- ☆ Аудитын дүгнэлт
- ☆ Хөдөлмөрийн хяналт
- ☆ Бодлогын баримт бичгийн хэрэгжилт
- ☆ Тайлан
- ☆ Бодлого, төлөвлөлт
- ☆ Төсөл, хөтөлбөр
- ☆ Хөдөлмөр эрхлэлтийн статистик мэдээлэл
- ☆ Статистик мэдээлэл

3. Нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг хэлэлцүүлээ.

Огноо: 2026-04-30

<https://mlsp.gov.mn/content/detail/4057>

Нүүр Яамны тухай ▾ Бодлого, чиглэл ▾ Мэдээ, мэдээлэл ▾ Хууль эрх зүй ▾ Ил тод ▾ Шилэн данс ▾

ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ

Төрийн үйлчилгээ ▾ Авлигын эсрэг үйл ажиллагаа e-Zasag.mn 1212.MN

Нүүр / Мэдээ, мэдээлэл / Цаг үеийн мэдээ / Дэлгэрэнгүй



Мэдээ 2026-04-30

Нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг хэлэлцүүлээ

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас Нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг танилцуулж, санал авах зорилгоор хэлэлцүүлгийг зохион байгууллаа.

Хэлэлцүүлэгт төрийн байгууллага, олон улсын байгууллага, төрийн бус байгууллага, судлаачид, иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл нийт 100 гаруй хүн оролцлоо.

Хэлэлцүүлгээс дараах саналыг онцолж байна:

-халамж, урамшуулал, гэр бүлийн хөгжлийг дэмжих үйлчилгээг ялгаж зааглан, нийгмийн халамжийг зорилтот бүлэгт чиглүүлэх;

-иргэдийн хэрэгцээ шаардлагад тулгуурласан бэлэн мөнгөний бус үйлчилгээг олон улсын жишигт нийцүүлэн хөгжүүлэх

-нийгмийн халамжийн арга хэмжээг хөдөлмөр эрхлэлттэй уялдуулах замаар өрх, иргэдийг ядуурлаас гаргах

-амьжиргаа багатай өрхийн гишүүдийн чадавхжуулах, бие даан амьдрах урт хугацааны үйлчилгээг шинээр нэвтрүүлэх,

-үйлчилгээг мэргэжлийн байгууллагаар гэрээлэн гүйцэтгүүлэх замаар үйлчилгээний үр ашгийг нэмэгдүүлж, төрийн бус байгууллага, иргэний нийгмийн байгууллагын хамтын ажиллагааг бэхжүүлэх зэрэг олон үр дүнтэй саналыг

Хайх

Хайх түлхүүр үг оруулна уу...

Ангилал

- ☆ Ярилцлага
- ☆ Санал авч байна
- ☆ Тайлан мэдээ
- ☆ Мэдээ
- ☆ Авлигын эсрэг үйл ажиллагаа
- ☆ Хүний нөөцийн удирлага
- ☆ Түгээмэл асуулт, хариулт
- ☆ Аудитын дүгнэлт
- ☆ Хөдөлмөрийн хяналт
- ☆ Бодлогын баримт бичгийн хэрэгжилт
- ☆ Тайлан
- ☆ Бодлого, төлөвлөлт
- ☆ Төсөл, хөтөлбөр
- ☆ Хөдөлмөр эрхлэлтийн статистик мэдээлэл

4. Амьжиргааны түвшин доогуур өрхийн усны хангамж, хүртээмжийг нэмэгдүүлэх асуудлаар санал солилцлоо

Огноо: 2026-03-19/

<https://mlsp.gov.mn/content/detail/3992>



Мэдээ 2026-03-19

Амьжиргааны түвшин доогуур өрхийн усны хангамж, хүртээмжийг нэмэгдүүлэх асуудлаар санал солилцлоо

Монголын Мянганы сорилтын сангаас буцалтгүй тусламж болгон Улаанбаатар хотын усны хангамжийг нэмэгдүүлэх төсөл хэрэгжүүлж байгаа бөгөөд салбарын яамд болон Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамтай усны үйлчилгээний тариф, тогтвортой байдлыг сайжруулах чиглэлээр хамтран ажиллаж байна.

Энэхүү хамтын ажиллагааны хүрээнд Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын дэд сайд Б.Солонгоо, Нийгмийн халамжийн бодлогын газрын дарга Ю.Отгонбилэг, Мянганы сорилтын корпорацийн Нийгмийн дүн шинжилгээ хариуцсан захирал Шэрон Рожерс, Монголын Мянганы сорилтын сангийн "Усны салбарын тогтвортой байдлыг хангах төсөл"ийн захирал Л.Өнөржаргал, бусад албан хаагчид оролцсон уулзалт зохион байгууллаа.

Уулзалтаар тус яамны зүгээс шинэчлэн боловсруулж байгаа Нийгмийн халамжийн тухай хуулийн төсөл болон дагалдах хуулийн төслүүдийг боловсруулж байгаатай холбогдуулан амьжиргааны түвшин доогуур өрхүүдийн усны хэрэглээ, хүртээмжийг нэмэгдүүлэх, тэгш байдлыг хангах асуудлаар санал солилцож, цаашид хамтран ажиллахаар болов.


👁 106

Хуваалцах: [f](#) [t](#)

5. Нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг иргэний нийгмийн байгууллагуудад танилцууллаа.

Огноо: 2025-10-31

<https://mlsp.gov.mn/content/detail/3846>

 ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ

Төрийн үйлчилгээ ▾ Авлигын эсрэг үйл ажиллагаа e-Zasag.mn 1212.MN

Нүүр / Мэдээ, мэдээлэл / Цаг үеийн мэдээ / Дэлгэрэнгүй



Мэдээ 2025-10-31

Нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг иргэний нийгмийн байгууллагуудад танилцууллаа

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам Нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон дагаж өргөн мэдүүлэх хуулийн төслүүдийг “Монфемнет Үндэсний Сүлжээ” ТББ-тай хамтран Иргэний нийгмийн байгууллагуудын төлөөлөл 30 гаруй байгууллагын тэргүүн, удирдах зөвлөлийн гишүүдэд танилцуулах уулзалтыг зохион байгууллаа.

ГБХНХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга Л.Мөнхзул уулзалтыг нээж, хэлсэн үгэндээ, “Хуулийн шинэчилсэн найруулгын төслийг хүүхэд, гэр бүлд чиглэсэн үйлчилгээг нийгмийн халамжийн бодлогоос салгах, нийгмийн халамжийн арга хэмжээг хөдөлмөр эрхлэлттэй уялдуулах замаар өрх, иргэдийг ядуурлаас гаргах, хүн амын ядуу, эмзэг байдалд өртсөн зорилтот өрх, иргэний амьжиргааг дэмжих, бие даан амьдрахад дэмжлэг үзүүлэхэд чиглэсэн үйлчилгээнүүдийг нэмэгдүүлэх бодлогыг баримтлан боловсруулсан” болохыг онцлон дурьдлаа.

Иргэний нийгмийн байгууллагуудын зүгээс ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, амьжиргаа багатай, хүчирхийлэлд өртсөн зэрэг зорилтот өрх, иргэний онцлог хэрэгцээнд нийцсэн үйлчилгээнүүдийг нэмэгдүүлэх, илүү тодорхой болгон тусгах, зөвхөн орлогоор биш боломжийг бий болгоход анхаарах, амьжиргаа багатай өрхийн хүүхдэд боловсролын дэмжлэг үзүүлэх зэрэг санал дэвшүүллээ.

433 Хуваалцах:  

Хайх

Хайх түлхүүр үг оруулна уу...

Ангилал

- ☆ Ярилцлага
- ☆ Санал авч байна
- ☆ Тайлан мэдээ
- ☆ Мэдээ
- ☆ Авлигын эсрэг үйл ажиллагаа
- ☆ Хүний нөөцийн удирлага
- ☆ Түгээмэл асуулт, хариулт
- ☆ Аудитын дүгнэлт
- ☆ Хөдөлмөрийн хяналт
- ☆ Бодлогын баримт бичгийн хэрэгжилт
- ☆ Тайлан
- ☆ Бодлого, төлөвлөлт
- ☆ Төсөл, хөтөлбөр
- ☆ Хөдөлмөр эрхлэлтийн статистик



**ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР,
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ**

НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬ /ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА/-ЫН ТӨСӨЛД ОЛОН НИЙТИЙН ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН САНАЛЫГ ТУСГАСАН ТАЙЛАН

**Улаанбаатар хот
2026 он**

**НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬ /ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА/-ЫН ТӨСӨЛД
ОЛОН НИЙТИЙН ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН САНАЛЫГ ТУСГАСАН БАЙДАЛ**

2026 оны 05 дугаар сарын 18

№	САНАЛ ӨГСӨН БАЙГУУЛЛАГА, ИРГЭНИЙ МЭДЭЭЛЭЛ	САНАЛ	САНАЛЫГ ТУСГАСАН БАЙДАЛ
Нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах Судалгааны дэд ажлын хэсгийн хэлэлцүүлэг, 2025.01.22-ны өдөр, танхимаар			
1.	М.Нямдорж МУБИС-ын Нийгмийн ажлын тэнхимийн багш	<ul style="list-style-type: none"> - Нэр томъёог сайтар нягтлах, үйл ажиллагаа, арга хэмжээ... - Нийгмийн ажилтан гэх үү, халамжийн нийгмийн ажилтан гэх үү, мэргэжилтэн гэх үү? нэр томъёог нэг талд нь гаргаж цэгцлэх шаардлагатай. - Зарчимд тэгш боломж олгох санааг тусгах - Хуулийн заалтуудыг нэр мөр ойлгоход анхаарч бичих 	<p>Саналыг тусгасан.</p> <p>Нэр томъёог сайжруулж, нэмсэн.</p> <p>Нийгмийн халамжийн мэргэжилтэн гэж нэгдсэн байдлаар хуулийн төсөлд тусгасан.</p> <p>Тэгш байдлыг хангах, тэгш бус байдлыг бууруулах агуулга бүхий заалтыг зарчимд тусгасан.</p>
2.	Болормаа судлаач	<ul style="list-style-type: none"> - Хуулийн төсөлд түлш, ундны ус, орон байрны асуудлыг шингээж өгвөл зүгээр - Тогтвортой ажил эрхэлж байгаа иргэн болон ажил олгогчийг яаж дэмжих - Австралид хамтран амьдрагчтай бол бага хэмжээтэй олгодог. /180 хоног гэдгээ хасах - Үерийн улмаас орон гэргүй болсон иргэдэд жишээ нь юу өгөх вэ? 	<p>Саналыг хэсэгчлэн тусгасан.</p> <p>Түлшний үнийн, усны дэмжлэгүүдийг тусгасан.</p> <p>Хуулийн төслийн 20 дугаар зүйлд Гэнэтийн аюулт үзэгдэл, эрсдэлт нөхцөлөөс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөг бууруулах үйлчилгээг шинээр тусгасан.</p>
3.	Б.Цэндсүрэн МУБИС-ын Нийгмийн ажлын тэнхимийн эрхлэгч	<ul style="list-style-type: none"> - Хуулийн төслийн үзэл баримтлал маш чухал - Согтуурах мансуурах донтой иргэн нэр томъёонд оруулах уу, иргэн өөрөө өөрчлөгдье гэвэл энэ их гоё заалт, гэсэн ч хэт хэт их массыг хамрах вий гэдгийг бодолцож үзээрэй. - Сургалтын байгууллагад суралцагчийн амьжиргааны дэмжлэгийн голч оноо өндөр байна. 	<p>Саналыг тусгасан.</p> <p>Үзэл баримтлалыг дахин сайжруулан батлуулсан.</p> <p>Согтуурах мансуурах донтой иргэний нэр томъёог нэмсэн.</p> <p>Сургалтын байгууллагад суралцагчийн амьжиргааны дэмжлэгийн голч оноог хассан.</p>

4.	П.Батжаргал ГБХНХЯ-ны ХШУДАГ-ын ахлах мэргэжилтэн	<ul style="list-style-type: none"> - Баян-Өлгий аймгийн багууд дээр АДЗ нээсэн, баг гэдгийн анхаарч хуульд оруулах, АДЗ-ийн урамшууллыг хассан байгааг анхаарах 	Саналыг тусгасан. Амьжиргааг дэмжих зөвлөлийг хуулийн төслөөс хассан.
5.	Д.Энхтуул СХД-ийн ХХҮХ-ийн дарга	<ul style="list-style-type: none"> - Хөгжлийн бэрхшээлтэй иргэн нийгмийн даатгалын шимтгэл төлсөн бол нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авдаг болгох. - Нийгмийн халамж улс төрөөс ангид байх зохицуулалтыг тусгах - Өрх толгойлсон нэр томьёог нарийвчлан тусгах, хамтран амьдрагчтай бол хамаарах эсэхийг тодорхой оруулах 	Саналыг тусгасан. Нийгмийн халамж улс төрөөс ангид байх зохицуулалтыг тусгасан. Өрх толгойлсон нэр томьёог нарийвчлан тусгасан ба хуулийн төслийн 4.1.22 дахь заалтад “өрх толгойлсон эх, эцэг” гэж нөхөр эсхүл эхнэр нас барсан, сураггүй алга болсон нь шүүхээр тогтоогдсон, эцэг, эх байх эрхээ шүүхийн шийдвэрээр хасуулсан, гэрлэлтээ цуцлуулсан, эцэг тодорхойгүйн улмаас эхээрээ овоглосон хүүхэдтэй бөгөөд гэрлэж байгаагүй шалтгаанаар хүүхдээ ганцаараа асран хамгаалж, харгалзан дэмжиж өрхийн амьжиргааны үндсэн эх үүсвэр, эдийн засгийн хариуцлагыг дангаар хүлээж байгаа ганц бие иргэнийг” гэж тусгасан.
6.	ГБХНХЯ-ны Хөдөлмөрийн бодлогын газрын дарга Д.Ренчиндорж	<ul style="list-style-type: none"> - Халамжийн байцаагчийн оруулбал мэргэжилтнүүдэд дэмтэй байх, энэ талыг судлах - Үйлчилгээг хувийн хэвшлээр гэрээлэн гүйцэтгүүлэхдээ бизнесийн бүлгийн хэмжээ хязгаар, ашиг сонирхлыг зохистой тусгах - Дотоод гарзын дарга нараас бичгээр санал авах - Сумын болон гэр хорооллын нийгмийн ажилтны цалин арай илүү байх зохицуулалт тусгах боломжтой эсэх - Амьжиргааг дэмжих зөвлөлийг сайжруулах 	Саналыг тусгасан. Нийгмийн халамжийн улсын байцаагчийн асуудлыг хуулийн төсөлд тусгасан. Амьжиргааг дэмжих зөвлөлийг хуулийн төслөөс хассан. Яамны дотоод газрын дарга нараас санал авч тусгасан.
7.	ХХҮЕГ-ын ахлах мэргэжилтэн Б.Нэргүй	<ul style="list-style-type: none"> - 10.4 дэх заалтыг хасах - Нас барсан тохиолдолд зогсоох хугацааг нарийвчлан оруулах - Асаргааны сургалтыг хэн зохион байгуулах, 	Саналыг тусгасан. Нас барсан тохиолдолд зогсоох хугацааг нарийвчлан тусгасан. Асаргааны сургалтыг мэргэжлийн

		<p>хаанаас санхүүжихийг тодорхой оруулах</p> <ul style="list-style-type: none"> - Бусад байгууллагын оролцоотой хэрэгжих үйлчилгээг хэрэгжүүлэх арга замыг яг тодорхой заахгүй бол дундаа хаягдах магадлалтай 	байгууллагаар гэрээлэн гүйцэтгүүлж, иргэн өөрөө төлөхөөр нарийвчлан тусгасан.
Хөгжлийн бэрхшээлтэй иргэний чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ТББ-уудын хэлэлцүүлэг, 2025.01.29-ны өдөр, танхимаар			
1.	<p>Энхчимэг:</p> <p>Эрхэм нандин сувд ТББ</p>	<ul style="list-style-type: none"> - Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд олгох халамжийн дэмжлэгийг яаж боломжийн болгох вэ гэдгийг сайн судлах - Унаагаар үйлчлэх-Өдрийн үйлчилгээ гэхгүй дэмжих үйлчилгээ гэвэл бүгд орно. - Зуслангийн хөнгөлөлт 100%, дагаж яах эцэг эх 50% болгох - Аарцаг эрхтэн-хүүхэд, иргэн гэхгүй хөгжлийн бэрхшээлтэй хүн гэж оруулах, учир нь хэвтрийн иргэн памперс хэрэгтэй. 	<p>Саналыг тусгасан.</p> <p>Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд олгох халамжийн үйлчилгээг нэмэгдүүлсэн. Мэргэжлийн хамтарсан зөвлөлийг аймаг, дүүргийн нийгмийн халамжийн байгууллагын дэргэд байгуулан, хэрэгцээт үйлчилгээг тодорхойлохоор тусгасан.</p>
2.	<p>Туяажаргал:</p> <p>Эрхэм нандин сувд ТББ</p>	<ul style="list-style-type: none"> - ОНОТХҮ үйлчилгээ нэмэхийг дэмжиж байна, үйлчилгээ их хэрэгтэй - Сувиллын хөнгөлөлтийг сувилалд яваад ирсний дараа олгодгийг өөрчлөх - Зуслан: ХБ-тэй Хүүхэд ганцаар зусланд явах боломжгүй тул асран хамгаалагчийн зардлыг хөнгөлөх давхар нийгэмшдэг хэрэгтэй, үйлчилгээ - Хөгжлийн бэрхшээлтэй хүнд урт хугацааны сэргээн засах үйлчилгээ чухал байгаа, яамд дундаа орхих вий гэдэг дээр анхаарах 	<p>Саналыг тусгасан.</p> <p>Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд олгох халамжийн үйлчилгээг нэмэгдүүлсэн. Мэргэжлийн хамтарсан зөвлөлийг аймаг, дүүргийн нийгмийн халамжийн байгууллагын дэргэд байгуулан, хэрэгцээт үйлчилгээг тодорхойлохоор тусгасан.</p>
3.	<p>Ганзориг:</p> <p>Монголын хараагүйчүүдийн үндэсний холбооны ерөнхийлөгч</p>	<ul style="list-style-type: none"> - Хуулийн зүйл, заалт сайжирсан нь давуу талтай байна. Буруу халамжийн бодлого өөрөө халамж хүртэгчийг нэмдэг. - Үйлчилгээг нэмсэн нь сайн байна. - ХБИ хөдөлмөр эрхлэхийг дэмжих нь чухал байна. - ХБИ-ний боловсрол эзэмшихийг дэмжих нь бодит дэмжлэг болно. 	<p>Саналыг тусгасан.</p> <p>Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд цэцэрлэг, сургуульд суралцах тохиолдолд унааны зардал олгодог байсныг бүх шатны боловсролын байгууллага, дэмжих төв, өдөр өнжүүлэх төв, хүүхэд харах үйлчилгээ болон бусад нийгмийн халамж, асрамжийн үйлчилгээний байгууллагад гэж өөрчилсөн.</p>

4.	Алтанзагас /Хөдөлмөрийн бэрхшээлтэй иргэн ажилчдын холбоо-танхим/	<ul style="list-style-type: none"> - Ахмад настан хүн хөгжлийн бэрхшээлтэй болдог, ахмад хэрнээ хөгжлийн бэрхшээлтэй хүний хувийг тогтоох заалт оруулах хэргэтэй. - 10кг хасаж холбоо хугацааны зардалд шингээх - Асаргаа шаардлагатай иргэнд ойр хороо дүүргээр өдрийн үйлчилгээ үзүүлдэг байх - Журмаа нэг хэлээр ярьдаг байх хэрэгтэй, дүүргүүд өөр өөрөөр хэрэгжүүлээд байна. 	<p>Саналыг тусгасан.</p> <p>Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүний бие даан амьдрах чадамж, хэрэгцээний цогц үнэлгээ хийх чиг үүрэг бүхий мэргэжлийн хамтарсан зөвлөл аймаг, дүүргийн нийгмийн халамжийн байгууллагын дэргэд ажиллахаар тусгасан. Хөгжлийн бэрхшээлтэй хүнд хувийн туслах үйлчилгээ, урт хугацааны сэргээн засалтын үйлчилгээ болон өдрөөр асрах, гэрээр асрах, түр болон урт хугацаагаар асрах асаргааны хувилбарт үйлчилгээ үзүүлэхээр хуулийн төсөлд тусгасан.</p>
5.	Мөнхцэцэг /Дундговь хараагүйчүүдийн холбоо/	<ul style="list-style-type: none"> - 15 хүн хасагдсан, харвалт саажилт - Хөгжлийн бэрхшээлтэй иргэн өндөр настнуудад өгөхгүй байгаа нь хэцүү байгаа. - Бүрэн харааны бэрхшээлтэй 3 хүн хасагдсан байна. заалт өссөн 	<p>Саналыг тусгах боломжгүй.</p> <p>Эдгээр асуудал нь журмын хүрээнд зохицуулагддаг. Байнгын асаргаа шаардлагатай иргэний өвчин, гэмтлийн жагсаалтыг шинэчлэн боловсруулж байна. Мөн хөдөлмөрийн чадвар алдалт тогтоох өвчний онош, байнгын асаргаа тогтоох өвчний оношнууд хоорондоо ялгаатай бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй хүн бүр асаргаанд орох боломжгүй юм.</p>
6.	Ц.Алтантуул /Сонсголын бэрхшээлтэй эцэг эхчүүд/:	<ul style="list-style-type: none"> - 1 дүгээр ангид орсон хүүхэд 7 дугаар ангидаа суралцахуйн бэрхшээлтэй болсон ба сонсгол, хэл яриан бэрхшээлтэй болсон - Дохионы хэлмэрчийн асуудлыг хуульд тусгах - Тэмдэглэл хөтлөгчийн цалингийн асуудлыг шийдэх - Дүнгийн суулгац-53,0сая төгрөг төрөөс өгдөг ч хүнд хүүхдэд сонсгол оруулах боломж муу байдаг. 	<p>Саналыг тусгах боломжгүй.</p> <p>Дохионы хэлмэрчийн асуудлыг хуульд тусгах, тэмдэглэл хөтлөгчийн цалингийн асуудлыг шийдэх нь Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн хүрээнд зохицуулагдана.</p>
7.	Уянга ХБХЭЭХолбоо ТББ	<ul style="list-style-type: none"> - Хүүхдийн нас 18 гэж хуульд оруулах – нийцүүлэх - ОНОТХУ хуульд сайн ч журам муугаас хэрэгждэггүй. - ТАТ амьжиргааны түвшин харж болохгүй. 	<p>Саналыг тусгасан.</p> <ul style="list-style-type: none"> - Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн насыг 18 гэж хуульд нийцүүлсэн. - Нийгмийн халамжийн улсын байцаагч ажиллуулах, хуульд хариуцлага тооцох

		- Хариуцлагын тогтолцоо яаж орж байгаа вэ	механизмыг тусгах замаар хариуцлагын тогтолцоог сайжруулахаар тусгасан.
8.	Оюунцэцэг /Эрхэм чанар/:	<ul style="list-style-type: none"> - Протез үйлчилгээ нэмэх хэрэгтэй - Тэргэнцэр үйлчилгээ бага байна - Эрээний тэргэнцэр хасах хэрэгтэй - Таяг 20,0 болих хэрэгтэй - Цооролтын гудас оруулах - Хувийн туслах асаргаа хэрэгтэй 	
9.	Элбэгдорж /ХБХЭЭХолбоо/:	<ul style="list-style-type: none"> - Байнгын асаргааны тэтгэмжийг ялгаатай ярих хэрэгтэй, насан туршдаа хэвтрийн байгаа хүний асаргааг ялгах хэрэгтэй - Хөгжлийн төв- Оршин суугаа орон нутагтаа яаж үйлчилгээ авахыг оруулах - Олон нийтэд түшиглэсэн хяналт, хэрэгжилт сайн байх 	Саналыг тусгасан. Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүний бие даан амьдрах чадамж, хэрэгцээний цогц үнэлгээ хийх чиг үүрэг бүхий мэргэжлийн хамтарсан зөвлөл аймаг, дүүргийн нийгмийн халамжийн байгууллагын дэргэд ажиллан тухайн иргэний хэрэгцээнд нийцсэн үйлчилгээг үзүүлэхээр тусгасан. Хөгжлийн бэрхшээлтэй хүнд хувийн туслах үйлчилгээ үзүүлэхээр тусгасан.
10.	Мөнхжаргал /Түгээмэл хөгжил/:	<ul style="list-style-type: none"> - Байнгын асаргааны тэтгэмж эсхүл хувийн туслах үйлчилгээний аль нэгийг авна. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуультай нийцэж байна. ХЭДС-аас санхүүжүүлэх нь зөв - Амралт, рашаан сувилал хүртээмжтэй болгох - Цооролтын гудас бас чухал 	Саналыг тусгасан. Хөгжлийн бэрхшээлтэй хүнд хувийн туслах үйлчилгээг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас санхүүжүүлэн үзүүлэхээр тусгасан. Туслах бүтээгдэхүүн, нэн шаардлагатай туслах хэрэгслийг хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд нарийвчлан тусгасан.
11.	Лхагваа/ Өвөрхангай/:	<ul style="list-style-type: none"> - 25 ажилтанд 1 хөгжлийн бэрхшээлтэй иргэн байх заалт өссөн үү, аймагт 25 ажилтантай компани цөөн байдаг - Хөдөлмөрийн чадавхаа 80%-аа алдсан хүн түлш 140,000 төгрөг бага байна. 	Саналыг Нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын хүрээнд шийдвэрлэх боломжгүй.
12.	Баатаржав /ХБИНХ/:	<ul style="list-style-type: none"> - Халамжийг мөнгөнөөс хол болгох - 1, 2 дугаар зэрэг, ваучер-сургууль - Мөнгө өгөөд байхаар олон сөрөг үр дагавартай байна - Хөгжлийн бэрхшээлтэй иргэний архи тамхинд 	Саналыг тусгасан. Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүний бие даан амьдрах чадамж, хэрэгцээний цогц үнэлгээ хийх чиг үүрэг бүхий мэргэжлийн хамтарсан зөвлөл

		донтсон иргэдэд тэтгэврийн хувиарлалтыг хасах..	аймаг, дүүргийн нийгмийн халамжийн байгууллагын дэргэд ажиллан тухайн иргэний хэрэгцээнд нийцсэн үйлчилгээг үзүүлэхээр тусгасан. Мөн үйлчилгээг нэмж тусгасан.
13.	Болороо /ГБХНХЯ/	<ul style="list-style-type: none"> - Хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхийн онцгой хуулийн шинэчилсэн найруулга - Хөнгөлөлт тусламжаа халамжийн хуульд оруулбал яасан юм бэ? - 1000+, 500 км+ гэж өссөн - Зуслан, рашаан сувилал 100%, асран хамгаалагч 50% гэж өссөн - Унааны зардал нэмж өссөн - 10кг шуудан илгээмжийг хассан 	Саналыг хэсэгчлэн тусгасан. Хөгжлийн бэрхшээлтэй хүний 10кг шуудан илгээмжийн зардлыг хассан. Мөн үйлчилгээг нэмж тусгасан.
Аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс, албадын дарга нарын хэлэлцүүлэг, 2025.01.29-ний өдөр, цахимаар			
1.	Хонгорзул /Хэнтий аймгийн ХХҮГ-ын дарга/	<ul style="list-style-type: none"> - Онцгой- 1.2 сая нэмэх, протез, ортопед нэмэх - Ахмадын шинэ төрлийн үйлчилгээ - Нийгмийн халамжийн тухай хуулийн төслийн 8,3 дахь заалтаас /сум хорооны нийгмийн халамжийн мэргэжилтэн/ гэсэн хэсгийг хасах саналтай. /Асаргаа тогтоолгох хүсэлтэй иргэдийг өрхийн эмч үзэж эргэн шалгуур үзүүлэлтийг үнэн зөв бодитой хийх бүрэн боломж бий./ - НХТ Хуулийн төслийн 29,1-д Нийгмийн ажлын мэргэжлээр дээд боловсрол эзэмшсэн гэсэн заалтын мэргэжлийн чиглэлийг нийтлэг болгох /Сум орон нутагт хүний нөөц дутагдалтай байдаг учир/ - Нийгмийн хамгааллын салбарт 10-с дээш жил үр дүнтэй ажилласан мэргэжилтнүүдийг нийгмийн ажилтан мэргэжил, мэргэшсэн гэсэн адилтган үзэх 	Саналыг хэсэгчлэн тусгасан. Мөнгөн дүнг хуулиар биш тогтоолын хүрээнд нэмэгдүүлэх тул хуулийн төсөлд тусгах боломжгүй. Хуулийн төслийн 8.3 дахь хэсгийг “Өрхийн болон сум, тосгоны эрүүл мэндийн төв нь энэ хуулийн 8.2-т заасан өвчин, гэмтлийн жагсаалт, Ахмад настны тухай хуулийн 4.1.7-д заасан үнэлгээг тус тус үндэслэн санал, дүгнэлтээ энэ хуулийн 8.4, 8.5-д заасан зөвлөл, комисст цахим эсхүл цаасан хэлбэрээр хүргүүлнэ.” Гэж өөрчлөн найруулсан. Нийгмийн халамжийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд 2028 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс өмнө сум, хорооны халамжийн нийгмийн ажилтнаар ажиллаж байсан төрийн захиргааны албан хаагчид энэ хуулийн 29.1 дэх хэсгийн Нийгмийн ажлын мэргэжлээр дээд боловсрол эзэмшсэн байх гэсэн нөхцөл

			хамаарахгүй байхаар тусгасан.
2.	Долгормаа /Дорноговь аймгийн ХХҮГ-ын дарга/	<ul style="list-style-type: none"> - Амьжиргааны эх үүсвэрээ алдсан гэдэг мэдээлэл боловсруулах, хаанаас мэдээллээ авах - Нийгмийн баталгааны санал - Амьжиргааг дэмжих зөвлөл байх шаардлагатай 	Саналыг тусгах шаардлагагүй. Нийгмийн баталгааны санал нь Төрийн албаны тухай хуулийн хүрээнд шийдвэрлэгдэнэ.
3.	Нямдэмбэрэл /Завхан/:	<ul style="list-style-type: none"> - Асаргааны тэтгэмж дээр өвчний оношийг тусгайлан зааж өгөх, эсхүл эрүүл мэнд рүү шилжүүлэх - Хорт хавдрын 4 дүгээр шат эдгэсэн тохиолдолд гарахгүй байх сонирхол байгаа тул нарийн зохицуулж өгөх нь 	Саналыг Нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын хүрээнд шийдвэрлэх боломжгүй.
4.	Н.Баярмаа /Сэлэнгэ/	<ul style="list-style-type: none"> - ВТЭК-оор асаргаа тогтоох нь зөв - БАШ хяналтын зардал тавьж болох уу НХ-ын Санд - Протез ортопед- ядуу ахмадууд нэхэмжлэхээр, бусад иргэд бэлнээр төлж авдаг байвал ямар вэ 	Саналыг Нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын хүрээнд шийдвэрлэх боломжгүй.
5.	Саранчимэг /Багахангай/:	<ul style="list-style-type: none"> - Нүүрсний 140,000 төгрөг нэмэгдүүлэх, тэтгэвэр дээр нэмж олгоно гэхээр гайхаад байна - ӨАТТС-Т зарим үйлчилгээг уялдуулж болохгүй байна. ХЭБ авдаг өрх 475 оноотой үнэлэгдсэн - 18-24 ӨХТТСтай уялдуулахгүй байх - БАШ буруу тогтоосон эмчид хариуцлага тооцдог байх - Асаргааны хувилбарт үйлчилгээнд - Кейсменежмент дэмжиж байна - Хараагүй- Брайль хасах - ОНОТХҮ үзүүлэх байгууллага байхгүй 	Саналыг тусгах шаардлагагүй.
6.	Эрдэнэдалай /Дундговь/- Нийгмийн ажилтан	<ul style="list-style-type: none"> - Хавдрын 3,4 дүгээр шатандаа байгаа үнэлгээний шалгуурыг янзлах асаргааны үнэлгээ 	Саналыг Нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын хүрээнд шийдвэрлэх боломжгүй.

7.	Дундговь:	<ul style="list-style-type: none"> - Байнгын асаргаа тогтоох асуудлыг мэдээлэлтэй болгох - Асаргаа ЭММЗ тогтоох - онош зөрдөг. 	Саналыг Нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын хүрээнд шийдвэрлэх боломжгүй.
8.	Дэлгэрмөрөн /Хөвсгөл/:	<ul style="list-style-type: none"> - Нийгмийн даатгалын 11 дүгээр зүйлд: 36 сар төлсөн тохиолдолд тэтгэвэрт орохгүй байна - Цаатны тэтгэмж- Хуульд оруулах, амьжиргааны түвшинтэй уялдуулахаар зардал их ороод байна. - АДЗ-г байх шаардлагатай 	Саналыг тусгах шаардлагагүй.
9.	Баярхүү /Багануур/:	<ul style="list-style-type: none"> - Тэжээн тэтгэх үр хүүхэдгүй бол ахмадын асаргаа өгч байвал ямар вэ, аав ээжийгээ асрах ёстой тул хүүхдэд хүнд асаргаа өгөхгүй байх 	Саналыг тусгах шаардлагагүй.
10.	Хишигдаваа /Дундговь/:	<ul style="list-style-type: none"> - Төрсөн хүүхэд асарч байгаа бол амьжиргааны түвшинтэй уявал зүгээр - Эмчийг хянах санаатай байна - 2лаа асаргаатай 2 ахмад нэгнээ асарна хуульд оруулах 	Саналыг хэсэгчлэн тусгасан. Хуулийн төслийн 37.3 дахь хэсэгт “Нийгмийн халамжийн байгууллага, Эрүүл мэндийн магадлалын зөвлөл, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 37.2.1-д заасан комисс, Мэргэжлийн хамтарсан зөвлөлөөс нийгмийн халамжид хамрагдах иргэнийг буруу тодорхойлж, хамрагдах шаардлагагүй иргэн нийгмийн халамжид хамрагдсан нь илэрсэн тохиолдолд буруутай этгээдэд холбогдох хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.” гэж заасан.
11.	Эрдэнэбат /Орхон/:	<ul style="list-style-type: none"> - Асаргааг эрүүл мэндийн байгууллагад шилжүүлбэл ямар вэ - Одонтой эх 	Саналыг тусгах боломжгүй. Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүний бие даан амьдрах чадамж, хэрэгцээний цогц үнэлгээ хийх чиг үүрэг бүхий мэргэжлийн хамтарсан зөвлөл аймаг, дүүргийн нийгмийн халамжийн байгууллагын дэргэд ажиллан тухайн иргэний хэрэгцээнд нийцсэн үйлчилгээг үзүүлэхээр тусгасан. Уг зөвлөлийн бүрэлдэхүүнд эмч ажиллана.

Олон улсын байгууллагатай хийсэн хэлэлцүүлэг, 2025.02.04-ний өдөр, танхимаар

1.	Н.Монголмаа, Дэлхийн банк	<ul style="list-style-type: none"> - Хуулийн төсөлд мэдээллийн сантай буюу амьжиргаатай холбоотой заалтууд байгаа нь сайн, гэхдээ зөвхөн доод гэлтгүй дунд хэсгээ бас анхаарах хэрэгтэй байгаа - Тэтгэвэр, тэтгэмжийг шаталсан хэлбэртэй өгвөл давхцал байсаар байна. - Нийгмийн даатгалтай сайн ... насны хишиг насны асуудал зэргийг нийтлэг том зургаар хараач, зарчмаар нь уях, хөдөлмөрийн хөлстэй уях уу? гэдэг бол зарчимд тохирох амьжиргаагаа сайн барих - Тэтгэмж алдах эрсдэлтэй байдаг тул хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлт-энийг яаж зохицуулах - Тогтвортой ажилтай болох хүртэл тэтгэмжийг олгож байх - Одоогийн байгаа эх, хүүхдийн үйлчилгээг Хуулиар салгасан ч адилхан нийгмийн халамжийн зардалд орно. - Дэлхийн банк зардал их байна өртөг ихтэй зорилтот бүлэгт сайн хүрэх - ЗМС-с hybridруу шилжиж байгаа дундаж амьжиргаатай хэсгээ анхаарах хэрэгтэй 	<p>Саналыг хэсэгчлэн тусгасан.</p> <p>Хуулийн төслийн 4.1.20 дэх заалтад “өрхийн мэдээллийн нэгдсэн сан” гэж Үндэсний статистикийн хороо, нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран баталсан аргачлалын дагуу өрхийн амьжиргааны түвшнийг тогтоож, оноогоор эрэмбэлсэн өрх, иргэний талаарх мэдээллийг;” гэж тусгасан.</p> <p>Нийгмийн халамжийн зарим тэтгэмж амьжиргааны түвшинтэй уялдсан бөгөөд зарим төрөл нь хүн амын бүлэгт чиглэсэн хэвээр байхаар тусгасан.</p>
2.	Энхцэцэг /ADB/:	<ul style="list-style-type: none"> - Хуульд ахиц дэвшил их байгаа, бэлтгэл ажлыг сайн хангах, сөрөг нөлөөнөөс сайн хамгаалах хэрэгтэй - Халамж-хөдөлмөртэй сайн уях хэрэгтэй - Мэдээллийн сангаа яаж бүрдүүлж, яаж хэрэглэх сайн ярих хэрэгтэй - Нийгмийн ажилтан хуульд нэг нэршилтэй болгох Төрийн захиргааны албан тушаалд хамаардаг гээд нийгмийн ажилтны мэргэжлийн үйлчилгээг хүргэдэггүй - Асаргааны сургалт хэрэгжихгүй байгаа тул ТББ-р хэрэгжүүлэх 	<p>Саналыг хэсэгчлэн тусгасан.</p> <p>Хуулийн төслийн 4.1.20 дэх заалтад “өрхийн мэдээллийн нэгдсэн сан” гэж Үндэсний статистикийн хороо, нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран баталсан аргачлалын дагуу өрхийн амьжиргааны түвшнийг тогтоож, оноогоор эрэмбэлсэн өрх, иргэний талаарх мэдээллийг;” гэж тусгасан.</p>

		<ul style="list-style-type: none"> - Үйлчилгээ үзүүлэгч байгууллагын чадавх гэдгийг бодох хэрэгтэй - Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ХЭД зөрчилддөг 	<p>Нийгмийн халамжийн зарим тэтгэмж амьжиргааны түвшинтэй уялдсан бөгөөд зарим төрөл нь хүн амын бүлэгт чиглэсэн хэвээр байхаар тусгасан.</p> <p>Нийгмийн халамжийн үйлчилгээнүүдийг хөдөлмөр эрхлэлтийн бодлоготой уялдуулан хэрэгжүүлэхээр тусгасан.</p>
3.	Ц. Болормаа /ADB/:	<ul style="list-style-type: none"> - ОНОТХҮ шалгуур заавраа баталсан гэж ойлгож байгаа - Төгсөлтийн аргачлал хэрэгжүүлэх маш нарийн зохицуулалттай, агентлаг хэр бэлтгэгдсэн байна вэ? 	<p>Саналыг тусгах шаардлагагүй.</p> <p>Төгсөлтийн аргачлал туршилтын хөтөлбөрийн арга, аргачлалд үндэслэн өрхийн амьжиргааг сайжруулах, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих цогц үйлчилгээг боловсруулж хуулийн төсөлд тусгасан.</p>
4.	Мөнхтуул /НҮБ-Хүүхдийн сан/:	<ul style="list-style-type: none"> - Гэр бүлийн хөгжлийг дэмжих тухай хууль зэрэг боловсруулагдаад явж байна, дунд нь юм үлдэх вий, 2 хуулиа зэрэг харах хэрэгтэй - Тэтгэвэр, тэтгэмж АДТ-д хүрэхгүй байх асуудал байна - Өмнөх үзүүлэлтээр авахаар зарим тохиолдолд хэцүү байна 	<p>Саналыг тусгах шаардлагагүй.</p>
5.	Алтантулга /JICA/:	<ul style="list-style-type: none"> - Ойрын хугацаанд батлуулах нь чухал байна. - Хүртээмжтэй, хүрэлцээтэй байх - Процесс хэсгийг нарийвчлан тусгавал хэрэгжилт илүү хялбар байна. - Нөхцөл тавихдаа болгоомжтой байх хэрэгтэй, шаардлагатай хэсэг үлдэх вий - Эрүүл мэндтэй холбоотой үйлчилгээг эрүүл мэнд рүү өгвөл яасан юм бэ, нийгмийн ажилтан үүнийг мэдэхгүй - Хасах тэтгэмжийг зоригтой хасах - Аргагчлалаа шинэчлэхдээ анхаарах - Өрхийн амьжиргааны түвшинтэй уялдаатай байх дунд дээд түвшинд үзүүлэх үйлчилгээ - ХЭДС зөв, үйлчилгээтэй холбох хэрэгтэй - Нийгмийн даатгал болон бусад хуультай уялдуулах 	<p>Саналыг хэсэгчлэн тусгасан.</p> <p>Нийгмийн халамжийн зарим тэтгэмж амьжиргааны түвшинтэй уялдсан бөгөөд зарим төрөл нь хүн амын бүлэгт чиглэсэн хэвээр байхаар тусгасан.</p> <p>Нийгмийн халамжийн үйлчилгээнүүдийг хөдөлмөр эрхлэлтийн бодлоготой уялдуулан хэрэгжүүлэхээр тусгасан.</p>

6.	Гантулга /МУЗН/:	<ul style="list-style-type: none"> - Дотоодын шилжин суурьшигчийн асуудал тусгасан эсэхийг анхаарч тусгах хэрэгтэй байна. 	<p>Саналыг хэсэгчлэн тусгасан. Хуулийн төслийн 13.15 дахь хэсэгт “Сум, хорооны нийгмийн халамжийн мэргэжилтэн нь хүнс тэжээлийн дэмжлэг авах зайлшгүй шаардлагатай оршин суух бүртгэлгүй энэ хуулийн 13.1-д заасан өрх, иргэнийг илрүүлж, кейс менежментэд үндэслэн зургаа хүртэлх сарын хугацаанд хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлж болно. Энэ хугацаанд улсын бүртгэлийн ажилтантай хамтран баримт бичгийн зөрчлийг арилган зохих нийгмийн халамжийн болон бусад арга хэмжээнд хамруулна.” гэж тусгасан.</p>
7.	Болормаа /ILO/:	<ul style="list-style-type: none"> - Иргэн, гадаадын иргэн харьяалалгүй хүнийг яах вэ. Жишээ нь: албадан хөдөлмөрт өртсөн гадаадын иргэн байна. - Гамшгийн үеийн үйлчилгээ нь 3 сараас өөр юм алга тэтгэвэр, тэтгэмж хэвтээ босоо тэлэлт байгаа юу? урьдчилан сэргийлэх нь чухал - Бүх нийтийн нийгмийн хамгааллын баталгааг хангахын тулд 3 хуулиа зэрэгцүүлж үзээд орхигдуулахгүй байх - 1 хүнд очих юмыг хасахаасаа илүү АДТ-тэй харьцуулж харах нь чухал 	<p>Саналыг тусгасан. Хуулийн төслийн 3.1 дэх хэсэгт “Нийгмийн халамжийн тухай хууль болон холбогдох хууль тогтоомжид заасан нөхцөл, шалгуурыг хангасан Монгол Улсын иргэн, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.7, 5.1.8-д заасан хүн нийгмийн халамжид хамрагдах эрхтэй.” Гэж заасан. Гэнэтийн аюулт үзэгдэл, эрсдэлт нөхцөлөөс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах, сөрөг нөлөөг бууруулах үйлчилгээг онцгой байдал, ус цаг уур, орчны хяналт шинжилгээ болон бусад холбогдох байгууллагатай мэдээлэл солилцож, хамтран хэрэгжүүлэхээр тусгасан.</p>
8.	Дэлхийн зөн олон улсын байгууллага:	<ul style="list-style-type: none"> - Төсвийн аргачлал хөтөлбөр төрөл болж байна - Хөдөлмөрийн хуультай уях, албан бус хөдөлмөр эрхлэгч - Өрхийн орлогыг нэмэгдүүлэх дээр борлуулалтыг нэмэх юмыг томъёолж оруулах, эрэлт нийлүүлэлт дээр анхаарах - Стандарт хангуулах дээр анхаарах нэмүү 	<p>Саналыг тусгасан. Хуулийн төслийн 34.3.3 дахь заалтад бүх шатны Засаг дарга нь газар тариалан, хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэх зорилгоор ядуу өрх, иргэнд газар олгох, эзэмшлийн газартаа тариа, ногоо тарих, малжуулах, нэмүү өртөг шингэсэн</p>

		<p>өртгийн том зургаар өрхийн бизнесийг дэмжих хэрэгтэй</p>	<p>бүтээгдэхүүн үйлдвэрлэх, худалдан борлуулахад нь дэмжлэг үзүүлэх зэргээр хөдөлмөр эрхлэх, тогтмол орлого олох боломжийг бүх талаар дэмжин ажиллахаар тусгасан.</p>
<p>Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн болон ТББ-ууд /ЭМЯ, НДЕГ, ХБХХЕГ, ХХҮЕГ, ТББ-ууд/% 2025.05.09-ний өдөр, танхимаар</p>			
1.	<p>НЭГ АСУУДАЛ-НЭГ ШИЙДЭЛ ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН САНАЛ</p> <p>/ХБХХЕГ-аас нэгтгэн ирүүлсэн/</p>	<ul style="list-style-type: none"> - Хөгжлийн бэрхшээлийг зөв тогтоох буюу хувь хүний ялгаатай хэрэгцээг тогтоох, түүнд нийцсэн үйлчилгээг санал болгох, сонголт хийх эрхийн боломжийг бий болгох. Тогтоох нь олон шат дамжлагатай бус, анхан шат дээрээ тогтоогддог буюу шаардлагатай үйлчилгээг шууд томъёолдог байх; - Үйлчилгээг картжуулсан хэлбэртэй байж болно; - Нийгмийн халамжийн үйлчилгээг үзүүлэхдээ амьжиргааны түвшин заах нь хүний эрхийг зөрчих буюу заавал хөгжлийн бэрхшээлтэй байх албагүй ба хүний үйлдлийн чадварт тохируулсан, хэрэгцээнд тулгуурласан суурь үйлчилгээг үзүүлэхэд чиглэгдэх /Хөгжлийн бэрхшээлтэй хүний хувьд амьжиргааны тэтгэмж гэж заахгүй, жишээлбэл, түр хөдөлмөрийн чадвараа алдсан хүнийг туслах хэрэгслээр хангах/. Амьжиргааны түвшин тогтоолгох биш, үйлдэл, үйл ажиллагааны алдагдлын хүрээнд шаардлагатай тусламж, хэрэгцээ буюу тохируулгатай үйлчилгээг өгөх; - Асаргааны тэтгэмжээс гадна нийгмийн үйлчилгээ буюу өдрийн үйлчилгээнүүдийг бий болгох. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг нөхөн сэргээх, нийгмийн, сэргээн засах, стресс менежмент, бүлгийн, хөгжлийн дэмжих төвүүд, үйлчилгээнүүдийг бий болгох; - Үйлчилгээний байгууллагуудыг заавал институтчлах биш бүлэг, дэмжих бусад 	<p>Саналыг дараах байдлаар бүрэн болон хэсэгчлэн тусгасан.</p> <p>Хөгжлийн бэрхшээлтэй хүнд бие даан амьдрах чадамж, хэрэгцээний цогц үнэлгээ хийх чиг үүрэг бүхий мэргэжлийн хамтарсан зөвлөл аймаг, дүүргийн нийгмийн халамжийн байгууллагын дэргэд ажиллуулахаар хуулийн төсөлд тусгасан. Уг зөвлөл нь хөгжлийн бэрхшээлтэй хүний бие даан амьдрах чадамж, хэрэгцээний цогц үнэлгээнд үндэслэн хувийн цогц төлөвлөгөө боловсруулах, төлөвлөгөөний дагуу хөдөлмөр эрхлэлт, нийгмийн халамж, эрүүл мэнд, боловсрол, сэргээн засах болон нийгмийн оролцоог дэмжих чадваржуулах үйлчилгээ, асаргааны хувилбарт болон хувийн туслах үйлчилгээ, урт хугацааны сэргээн засалтын үйлчилгээ тохирох хэрэглэгдэхүүн, нэн шаардлагатай туслах бүтээгдэхүүний дэмжлэгт холбон зуучлах, хэрэгжилтэд хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллана. Мэргэжлийн хамтарсан зөвлөлийг 2029 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс ажиллуулахаар тусгасан бөгөөд энэ хугацаанд ахмадын эсхүл сэргээн засалтын эмч, согог зүйч, хөдөлгөөн засалч, хэл засалчийг бэлтгэх ажлыг Нийгмийн халамжийн болон эрүүл</p>

		<p>хэлбэрээр зохион байгуулах;</p> <ul style="list-style-type: none"> - Нэг өрхөд очих асаргаа, тэтгэмж, үйлчилгээний давхцал.... Хэрэгцээнд үндэслэн халамж, тэтгэврийн тогтолцоо байх. Хэрэглээ нь дундын буюу давхацдаг бол түүнийг өрхөд өгөхдөө давхцуулахгүй байж болно; - Байнгын асаргаа шаардлагатай хүмүүсийн хувьд тухайн хүнийг биеэр байлцуулахгүйгээр холбогдох материалыг бүрдүүлдэг байх; - Хүүхдийн нэмэлт, жирэмсэн, нөхөн үржихүйн зарим зардлыг, суралцахад шаардлагатай туслах, дэмжих хэрэгсэл, эм тариа, дэвшилтэд технологийн хэрэгслийн зардлыг санхүүжүүлэх механизмыг бий болгох; - Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үйлчилгээ үзүүлэх байгууллагуудыг бий болгоход гарааны үед, хүний нөөцийг бэлтгэх, чадавхжуулах, үйлчилгээг түгээн дэлгэрүүлэхэд төрөөс дэмжих; - Халамж, асрамжийн үйлчилгээг иргэн өөрөө, гэр бүл нь сонгон эхлээд гэр бүлээс төлбөр, тооцоог хийж үйлчилгээг авах механизмыг бүрдүүлэх буюу үйлчлүүлэгч үйлчилгээний байгууллагуудын хоорондын сэтгэл зүй, харилцаа, хариуцлагын эерэг тогтолцоог бий болгох; - Хөгжлийн бэрхшээлтэй болохоос урьдчилан сэргийлэх нийгмийн үйлчилгээ иргэн бүрд хэрэгтэй; - Урт хугацааны сэргээн засах үйлчилгээг аль болох түгээн дэлгэрүүлэх, түр зуурын, нэг, хоёр долоо хоногийн үйлчилгээ үзүүлэх байдлаар хязгаарлагдахгүй байх; - Үйлчилгээний субъект нь зөвхөн хөгжлийн бэрхшээлтэй иргэн рүү чиглэгдэх бус түүний гэр бүлд байгаа хүүхэд, гишүүдэд чиглэгдэх. 	<p>мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, төрийн захиргааны байгууллага, аймаг, дүүргийн нийгмийн халамжийн болон эрүүл мэндийн асуудал хариуцсан байгууллагууд хамтран зохион байгуулна.</p> <p>Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд цэцэрлэг, сургуульд суралцах тохиолдолд унааны зардал олгодог байсныг бүх шатны боловсролын байгууллага, дэмжих төв, өдөр өнжүүлэх төв, хүүхэд харах үйлчилгээ болон бусад нийгмийн халамж, асрамжийн үйлчилгээний байгууллагад гэж өөрчилсөн.</p> <p>Мөн хуулийн төслийн 26.8 дахь хэсэгт “хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийг дэмжих төвийн үйлчилгээг иргэн, хуулийн этгээдээр гэрээлэн гүйцэтгүүлэх зардлыг хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын төсөвт жил бүр тусган хэрэгжүүлнэ.” гэж нэмж тусгасан.</p> <p>Хөгжлийн бэрхшээлтэй хүнд үзүүлэх үйлчилгээнүүд нь хувийн туслах үйлчилгээ, урт хугацааны сэргээн засалтын үйлчилгээ болон өдрөөр асрах, гэрээр асрах, түр болон урт хугацаагаар асрах асаргааны хувилбарт үйлчилгээ үзүүлэхээр олон хувилбартай байхаар хуулийн төсөлд тусгасан.</p> <p>Асаргааны хувилбарт үйлчилгээг үзүүлснээр асаргаа шаардлагатай хүн, түүний гэр бүлийн гишүүдийг дэмжинэ. Мөн асаргааны үйлчилгээг мэргэжлийн</p>
--	--	--	---

			байгууллагаар гэрээлэн гүйцэтгүүлснээр ажлын байрыг нэмэгдүүлэх зэрэг олон талын ач холбогдолтой юм.
“НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ШИНЭЧЛЭЛ” хэлэлцүүлэг, 2026.04.30-ны өдөр, танхимаар			
1.	Э.Энхчимэг, Эрхэм нандин сувд ТББ-ын тэргүүн	<ul style="list-style-type: none"> - 18 нас хүрэхээр асаргааны тэтгэмж хасаж байгааг болих - Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дундаж наслалтыг тогтоох, түүнд үндэслэн тэтгэвэр, тэтгэмжийн насыг тогтоох, тохирсон үйлчилгээг хүргэх хэрэгтэй. 	Саналыг тусгасан. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн амьжиргааг дэмжих тэтгэмжийг 18 нас хүртэл олгож, 18 наснаас эхлэн хөгжлийн бэрхшээлтэй иргэнд олгох амьжиргааг дэмжих тэтгэмжид хамрагдахаар заасан. Асаргааны тэтгэмжийг мөн хугацааны хувьд үргэлжлүүлэн тогтоон олгохоор хуулийн төсөлд тусгасан.
2.	А.Энхбаатар, Монголын Сонсголгүй иргэдийн үндэсний холбооны ерөнхийлөгч	<ul style="list-style-type: none"> - Сонсголгүй болон хараагүй иргэдийн хэрэгцээ нэмэгдэж байна. Тиймээс тэдэнд тохирсон, онцлогт нийцсэн нийгмийн халамжийн үйлчилгээг хүргэх хэрэгтэй. 	Саналыг тусгасан. Хөгжлийн бэрхшээлтэй хүнд бие даан амьдрах чадамж, хэрэгцээний цогц үнэлгээ хийх чиг үүрэг бүхий мэргэжлийн хамтарсан зөвлөл аймаг, дүүргийн нийгмийн халамжийн байгууллагын дэргэд ажиллуулахаар хуулийн төсөлд тусгасан. Уг зөвлөл нь хөгжлийн бэрхшээлтэй хүний бие даан амьдрах чадамж, хэрэгцээний цогц үнэлгээнд үндэслэн хувийн цогц төлөвлөгөө боловсруулж, тэдний онцлог, хэрэгцээнд нийцсэн үйлчилгээг хүргэн ажиллахаар хуулийн төсөлд тусгасан.
3.	Ц.Сүхбаатар, Монголын ахмадын холбооны ерөнхийлөгч	<ul style="list-style-type: none"> - Халамж хавтгайраагүй гэдгийг олон нийтэд ойлгуулах, улс төрчид ч тэр өнцгөөс тайлбарладаг байх нь чухал байна. - Ахмадын хуульд дагаж нэлээд өөрчлөлт орж байгаа юм байна. Нийт ахмадын 67.5 хувь нь хөдөлмөр эрхлэх чадвартай, сонирхолтой байдаг. - Асаргаа шаардлагатай ахмадын тоо жил ирэх тусам нэмэгдэж байна. 	Саналыг тусгасан. Нийгмийн халамжийн шинэчлэлийн хүрээнд халамжийг зорилтот хэсэгт чиглүүлж байгаатай холбоотойгоор одоогийн Нийгмийн халамжийн тухай хуулийн хүрээнд амьжиргааны түвшин харгалзахгүй олгодог эх хүүхдийг дэмжихэд чиглэсэн тэтгэмж, тусламжийг нийгмийн халамжийн бодлогоос зааглаж, Гэр бүлийн хөгжлийг дэмжих тухай хуулийн

			<p>төсөлд тусган боловсруулсан.</p> <p>Ахмад настны тухай хуулийн хүрээнд ахмад настанд бие даах чадварын цогц үнэлгээг хийж, асаргаа шаардлагатай ахмадад асаргааны хувилбарт үйлчилгээнүүдийг үзүүлэх, бусад ахмад настнуудад эрүүл идэвхтэй насжилтыг дэмжих үйлчилгээнд хамруулахаар тусган хэрэгжүүлж байна.</p> <p>Ахмад настны тоо жил бүр нэмэгдэж байгаатай холбогдуулан амьжиргааг дэмжих тэтгэмжийн насыг 65 нас болгон өөрчилсөн.</p>
4.	н.Баасан, Ахмадын чөлөөт холбооны тэргүүн	<ul style="list-style-type: none"> - Халамжид хяналтын тогтолцоо сайн байх хэрэгтэй. - Урамшуулал халамж 2 одоогийн хуульд холилдож хэрэгждэг, үүнийг салгах нь чухал. - Халамж эзнээ олдоггүй. Яг хэрэгтэй хүн нь хамрагдаж чаддаггүй, шимэгчид ихтэй байдаг. - Халамжийн орц /төсөв/ их ч хулгай ихтэйгээсээ болоод гарц муутай байдаг. - Нийгмийн ажилтнуудыг стандартын дагуу бэлдэх хэрэгтэй. - Ядуурлаас гарч байгаа өрх, иргэнийг урамшуулах хэрэгтэй. Үүнийг яаж урамшуулахаар хуулийн төсөлд тусгагдаж байгаа вэ? 	<p>Саналыг тусгасан.</p> <p>Нийгмийн халамжийн улсын байцаагчийг ажиллуулах, хариуцлага тооцох зохицуулалтыг хуулийн төсөлд тусгасан. Ингэснээр хяналт, хариуцлагын тогтолцоо илүү сайжирна.</p> <p>Нийгмийн халамжийн мэргэжилтнийг нийгмийн ажлын бакалавр, түүнээс дээш зэрэгтэй байхаар хуулийн төсөлд тусгасан бөгөөд мэргэжлийн нийгмийн ажлын үйлчилгээг хүргэхээр тусгасан.</p>
5.	Б.Чулуундолгор, Тэргэнцэртэй иргэдийн холбооны тэргүүн	<ul style="list-style-type: none"> - Асран хамгаалагчийг субъект болгож оруулж өгөх хэрэгтэй. Бид асаргаатай иргэд, асран хамгаалагчийн тоон үзүүлэлт дээр судалгаа гаргаж байна. - Үйлчилгээг олон төрөл, хэлбэртэйгээр томьёолох хэрэгтэй. - Үйлчилгээг ТББ, Иргэний нийгмийн байгууллагаар гүйцэтгүүлэх, хяналт тавих, чанартай тайлагнах асуудлыг анхаарч үзэх хэрэгтэй. 	<p>Саналыг тусгасан.</p> <p>Хөгжлийн бэрхшээлтэй хүнд үзүүлэх үйлчилгээнүүд нь хувийн туслах үйлчилгээ, урт хугацааны сэргээн засалтын үйлчилгээ болон өдрөөр асрах, гэрээр асрах, түр болон урт хугацаагаар асрах асаргааны хувилбарт үйлчилгээ үзүүлэхээр олон хувилбартай байхаар Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн</p>

			төсөлд тусгасан. Асаргааны хувилбарт үйлчилгээг үзүүлснээр асаргаа шаардлагатай хүн, түүний гэр бүлийн гишүүдийг дэмжинэ. Мөн асаргааны үйлчилгээг мэргэжлийн байгууллагаар гэрээлэн гүйцэтгүүлснээр ажлын байрыг нэмэгдүүлэх зэрэг олон талын ач холбогдолтой юм.
6.	Алтанзул, Сонсголын бэрхшээлтэй иргэнийн	<ul style="list-style-type: none"> - Сонсголын бэрхшээлтэй 258 хүүхэд ЕБС-д сурдаг ч 79% нь бичиг үсгийн чадваргүй байна. Үүнийг анхаарч, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсролын асуудалд онцгой анхаарах хэрэгтэй. - Халамжаас хөдөлмөрт хэрхэн шилжих вэ, ХЭДСангийн зээлийн материал өгсөн ч зээлийн шийд гарахгүй удаж байна. - Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд тохируулгад орчин хэрэгтэй байна. - Ахмад настны халамжийн тэтгэвэр, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асаргааны тэтгэмжийн хэмжээг амьжиргааны доод түвшинд хүргэн нэмэгдүүлэх хэрэгтэй байна. 	Саналыг тусгасан. Хөгжлийн бэрхшээлтэй хүнд бие даан амьдрах чадамж, хэрэгцээний цогц үнэлгээ хийх чиг үүрэг бүхий мэргэжлийн хамтарсан зөвлөл аймаг, дүүргийн нийгмийн халамжийн байгууллагын дэргэд ажиллуулахаар хуулийн төсөлд тусгасан. Уг зөвлөл нь хөгжлийн бэрхшээлтэй хүний бие даан амьдрах чадамж, хэрэгцээний цогц үнэлгээнд үндэслэн хувийн цогц төлөвлөгөө боловсруулж, тэдний онцлог, хэрэгцээнд нийцсэн үйлчилгээг хүргэн ажиллахаар хуулийн төсөлд тусгасан. Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн амьжиргааг дэмжих болон асаргааны тэтгэмжийн хэмжээг ялгаатай тогтоохоор хуулийн төсөлд тусгасан. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хэрэгжилттэй холбоотой асуудалд хариулт өгсөн. /ХХҮЕГ/
7.	С.Жигжидпүрэв, НҮБ-ын Хүнс хөдөө аж ахуйн байгууллагын мэргэжилтэн	<ul style="list-style-type: none"> - Уур амьсгалын өөрчлөлтийн улмаас амьжиргаа муудаж байгаа өрх, иргэн олон байна. Үүнээс гадна гэнэтийн осол аваарын улмаас амьжиргаа гэнэт огцом доройтох тохиолдол байна. Жишээ нь Өвөрхангайгаас идэшний цагаар мах борлуулахаар хот явж байсан 2 гэр бүлийн 4 хүн ослоор нас барсан. Уламжлалт өв соёлоо харгалзаж үзсэн 	Саналыг тусгасан. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нь гэнэтийн аюулт үзэгдэл, эрсдэлт нөхцөлөөс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах, сөрөг нөлөөг бууруулах үйлчилгээг онцгой байдал, ус цаг уур, орчны хяналт шинжилгээ болон бусад холбогдох байгууллагатай мэдээлэл

		<p>цочролд хариу үзүүлэх нийгмийн хамгааллын үйлчилгээ чухал байна.</p> <ul style="list-style-type: none"> - Цочролд хариу үзүүлэх нийгмийн хамгааллын үйлчилгээний хүрээнд НҮБ-аас хүүхдийн мөнгөн тэтгэмжийг тодорхой хугацаанд нэмэгдүүлэн олгож байсан туршлага байна. Эндээс сум орон нутгийн захиргаа нийгмийн халамжийн харилцан ойлголцол, хамтын ажиллагаа маш чухал байх ёстой нь харагдаж байсан. - Орон нутгийн онцлог, тухайн үеийн нөхцөл байдалд тохирсон арга хэмжээ авах боломжтой цонх заалтыг оруулбал зүгээр, олон улсад ийм зохицуулалтууд байдаг. 	<p>солилцож, хамтран хэрэгжүүлэхээр хуулийн төсөлд тусгасан.</p> <p>Мөн аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал нь өрх, иргэнийг гэнэтийн аюулт үзэгдэл, эрсдэлт нөхцөлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, нэрвэгдсэн өрх, иргэнд дэмжлэг, үйлчилгээ үзүүлэх журам баталж, зардлыг жил бүрийн төсөвт тусган баталж хэрэгжүүлэхээр хуулийн төсөлд тусгасан.</p> <p>Гэнэтийн аюулт үзэгдэл, эрсдэлт нөхцөлд өртсөний улмаас орон гэргүй болсон, орон гэр нь цаашид амьдрах боломжгүй болсон өрхөд нэг удаагийн дэмжлэг олгох заалтыг нэмж тусгасан.</p>
8.	Д.Амартүвшин, ХУД-ийн ХХҮГ-ын дарга	<ul style="list-style-type: none"> - Эх, хүүхдэд чиглэсэн бодлогыг өөр хуулиар зохицуулах хэрэгтэй, халамж хавтгайрсан зүйл байхгүй, иргэдийн ойлголтыг зөв болгох нь чухал байна. - Амьжиргаанд үндэслэж олгодог хөтөлбөр бол хүнсний эрхийн бичгийн үйлчилгээ байдаг. Амьжиргаанд үндэслэсэн хөтөлбөрүүдийг нэмэх хэрэгтэй. - Боловсролын дэмжлэг чухал хэрэгтэй байна. СӨБ, ЕБС-ийн гэх мэт. 	<p>Саналыг тусгасан.</p> <p>Нийгмийн халамжийн шинэчлэлийн хүрээнд халамжийг зорилтот хэсэгт чиглүүлж байгаатай холбоотойгоор одоогийн Нийгмийн халамжийн тухай хуулийн хүрээнд амьжиргааны түвшин харгалзахгүй олгодог эх хүүхдийг дэмжихэд чиглэсэн тэтгэмж, тусламжийг нийгмийн халамжийн бодлогоос зааглаж, Гэр бүлийн хөгжлийг дэмжих тухай хуулийн төсөлд тусган боловсруулсан.</p> <p>Зарим төрлийн тэтгэмж, дэмжлэг, үйлчилгээг амьжиргааны түвшинд үндэслэн олгохоор хуулийн төсөлд тусгасан.</p>
9.	Б.Бямбадорж, Нийслэлийн ЗДТГ-ын Нийгмийн бодлогын газрын дарга	<ul style="list-style-type: none"> - Хуулийн төслийг боловсруулахдаа ирээдүйгээ харж боловсруулах нь чухал. Насжилт жил ирэх тусам нэмэгдэж байна. Эдгээрт нийцүүлэн ажиллах шаардлага тулгарч байна. - НЗДТГ-ын дэргэд нийгмийн хамгааллын тусгай төв, Хүүхэд залуучуудын хөгжлийн тусгай төвүүд байдаг. Хуулийн төсөлд эдгээр 	<p>Саналыг хэсэгчлэн тусгасан.</p> <p>Хөгжлийн бэрхшээлтэй хүнд үзүүлэх үйлчилгээнүүд нь хувийн туслах үйлчилгээ, урт хугацааны сэргээн засалтын үйлчилгээ болон өдрөөр асрах, гэрээр асрах, түр болон урт хугацаагаар асрах асаргааны хувилбарт үйлчилгээ үзүүлэхээр олон</p>

		<p>байгууллагын саналыг авч уламжилна.</p> <ul style="list-style-type: none"> - Олон улсад 7 дугаар ангиас төрөлжсөн мэргэжлийн сургалт явуулдаг практик байдаг. Өөрөөр хэлбэл сонгосон мэргэжлээр нь эртнээс бэлддэг. Үүнийг судалж хэрэгжүүлэх, орчин цагт хиймэл оюун ухааны шилжилт хүчтэй өрнөж байгааг анхаарах хэрэгтэй. - Урт хугацааны асаргааны үйлчилгээг хөгжүүлэх, гэр бүлийн асаргааны ачааллыг бууруулах, хуваалцах үүднээс мэргэжлийн асрагчийг бэлтгэн ажиллуулах хэрэгцээ шаардлага бий болж байна. 	<p>хувилбартай байхаар Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд тусгасан. Асаргааны хувилбарт үйлчилгээг үзүүлснээр асаргаа шаардлагатай хүн, түүний гэр бүлийн гишүүдийг дэмжинэ. Мөн асаргааны үйлчилгээг мэргэжлийн байгууллагаар гэрээлэн гүйцэтгүүлснээр ажлын байрыг нэмэгдүүлэх зэрэг олон талын ач холбогдолтой юм.</p>
--	--	---	---

**АЙМАГ, ДҮҮРГИЙН ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗАР, ХЭЛТСЭЭС
НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬ /ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА/-ЫН ТӨСӨЛД ӨГСӨН САНАЛ**

2025.05.27

№	ХУУЛИЙН ТӨСЛИЙН ЗААЛТ	САНАЛ	САНАЛЫГ ТУСГАСАН БАЙДАЛ
1	4.1.2: “Өрхийн мэдээллийн нэгдсэн сан” гэж Үндэсний статистикийн хороо, нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран баталсан аргачлалын дагуу өрхийн амьжиргааны түвшнийг тогтоож, оноогоор эрэмбэлсэн өрх, иргэний талаарх мэдээллийг;	Өрх иргэний амьжиргааны түвшнийг харгалзаж нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, дэмжлэгийн үйлчилгээг үзүүлэх шинэ заалтууд нэмэгдэж байгаа тул өрхийн амьжиргааны түвшний оноо бодох аргачлалыг сайжруулж зорилтот бүлгийн өрх иргэний амьжиргааны түвшнийг үнэн бодитой тодорхойлох	Саналыг тусгасан. Мэдээллийн сантай холбоотой заалтыг нэмж тусгасан.
2	4.1.7. “бүтэн өнчин хүүхэд” гэж эцэг, эх нь хоёул тогтоогдоогүй, нас барсан, сураггүй алга болсон, эрх зүйн чадамжгүй болон эцэг, эх байх эрхээ шүүхийн шийдвэрээр хязгаарлуулсан, хасуулсан бол тухайн шийдвэр хүчин төгөлдөр байх хугацаанд, түүнчлэн эцэг тодорхойгүйн улмаас эхтэйгээ амьдарч байгаад эх нь нас барсан, гэр бүл салсны улмаас асрамждаа авсан эх /эцэг/ нь нас барсан 18 хүртэлх насны хүүхдийг;	4.1.7 “гэр бүл салсны улмаас асрамждаа авсан эх /эцэг/ нь нас барсан” гэснийг хасах	Тусгах шаардлагагүй санал.
3	4.1.8: “Өрх толгойлсон эх, эцэг” гэж нөхөр эсхүл эхнэр нас барсан, сураггүй алга болсон нь шүүхээр тогтоогдсон, эцэг, эх байх эрхээ шүүхийн шийдвэрээр хязгаарлуулсан, хасуулсан бол тухайн шийдвэр хүчин төгөлдөр байх хугацаанд, гэрлэлтээ цуцлуулсан, гэрлэж байгаагүй боловч төрүүлсэн, үрчлэн авсан хүүхэдтэй ганц бие иргэнийг;	Гэрлэж байгаагүй боловч төрүүлсэн, үрчлэн авсан хүүхэдтэй ганц бие иргэнийг гэснийг илүү тодорхой болгох	Тусгах шаардлагагүй санал.

14	7.1.1.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн Тайлбар хэсэгт заасан насанд хүрсэн бөгөөд өрхийн амьжиргааны түвшин нь босго шугамаас доогуур үнэлэгдсэн өрхийн ахмад настан;бөгөөд өрхийн амьжиргааны түвшин нь босго шугамаас доогуур үнэлэгдсэн өрхийн.... гэснийг хасах	Тусгах шаардлагагүй санал.
5	8.1.3. Тэжээн тэтгэх хүүхэдгүй, ганц бие ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй ганц бие иргэнийг гэр бүлдээ авч асрамжилж байгаа иргэн:	Асаргаанд байх шаардлагагүй ганц бие ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй ганц бие иргэн нь өдөр тутмын үйлдлийг бие даан гүйцэтгэх чадвартай, өөрийн нэр дээр үл хөдлөхийн бүртгэлтэй, өөрийн гэсэн гэр оронтой хүнийг гэр бүлтэй авч асрамжлах нь тохиромжгүй тул энэ заалтыг илүү оновчтой тодорхой болгох шаардлагатай.	Тусгах шаардлагагүй санал.
6	8.1.4. Бүтэн өнчин хүүхдийг үрчлэн авсан, Гэр бүлийн тухай хуулийн 25.5-д заасан болон хүчирхийллийн улмаас сэтгэл санааны, бие махбодын хохирол хүлээж хамгаалалт шаардлагатай болсон хүүхдийг гэр бүлдээ авч асрамжилж байгаа;	Бүтэн өнчин хүүхдийг үрчлэн авсан гэснийг хасах	Тусгах шаардлагагүй санал.
7	8.1.5.18 хүртэлх насны гурав болон түүнээс дээш хүүхэдтэй эсхүл хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй бол 2 ба түүнээс дээш хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэг	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй бол 2 ба түүнээс дээш хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэг гэсэн заалтыг илүү тодорхой болгож, 18 хүртэлх насны аль нэг хүүхэд нь хөгжлийн бэрхшээлтэй бол 2 ба түүнээс дээш хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэг гэж нэмэх	Саналыг тусгасан. Бичвэрийн найруулгыг зассан.
8	8.7.Энэ хуулийн 8.4, 8.5, 8.6-д заасан зөвлөл, комисс нь байнгын асаргаа шаардлагатайг тогтоох, хугацааг сунгахдаа иргэнийг зайлшгүй биеэр байлцуулах шаардлагатайгаас бусад тохиолдолд холбогдох нотлох баримтад үндэслэнэ.	Оршин суух хаягтаа 180 хоногоос дээш хугацаагаар амьдраагүй бол байнгын асаргаа шаардлагатай болохыг тогтоох, сунгах асуудлыг шийдвэрлэхгүй байх талаар заалт оруулах (кэйс элбэг тохиолддог)	Саналыг тусгасан. Заалтыг хуулийн төслөөс хассан бөгөөд журамд нарийвчлан тусгахаар шийдвэрлэсэн.

9	8.10 Байнгын асаргаа шаардлагатай ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүн нь асаргааны хувилбарт үйлчилгээнд хамрагдсан тохиолдолд энэ хуулийн 8.1.1, 8.1.2-т заасан тэтгэмжийг тухайн хугацаанд давхардуулан олгохгүй.	Энэ үйлчилгээг авахад тэтгэмж зогсвол иргэд энэ үйлчилгээг авахгүй. Хэрэгжилт хангалтгүй үр дүн гарахгүй байх	Тусгах шаардлагагүй санал. Ижил төрлийн үйлчилгээг давхардуулан олгохгүй байх зарчмыг баримталсан.
10	8.11 Энэ хуулийн 8.1.1, 8.1.2-т заасан иргэнд асаргаа, сувилгаа, сэтгэл зүй болон хүний эрхийн сургалтыг аймаг, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага нь иргэн, хуулийн этгээдээр гэрээлэн гүйцэтгүүлж, зардлыг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас санхүүжүүлнэ.	Нийгмийн халамжийн үйлчилгээтэй холбоотой зардлыг Нийгмийн халамжийн сангаас гаргах	Саналыг тусгасан.
11	8.16. Өрх толгойлсон эх, эцэг нь хууль ёсоор гэрлэлтээ бүртгүүлээгүй боловч Гэр бүлийн тухай хуулийн 21.5-д заасан хүүхэдтэй эсхүл Иргэний хуулийн 126.2-т заасан хамтран өмчлөх дундын өмчтэй эсхүл 180 хоногоос дээш хугацаагаар нэг гэрт амьдарч байгаа хамтран амьдрагчтай бол энэ хуулийн 8.1.5-д заасан тэтгэмжийг олгохгүй.	...180 хоногоос дээш хугацаагаар нэг гэрт амьдарч байгаа хамтран амьдрагчтай бол гэдгийг ямар шалгуураар, юуг үндэслэж тогтоох гэдгийг тодорхой заах	Саналыг журамд нарийвчлан тусгана.
12	9.2.Энэ хуулийн 7.1-д заасан хүнд олгох халамжийн тэтгэврийн хэмжээг ахмад настанд өрхийн амьжиргааны түвшинтэй уялдуулан, хөгжлийн бэрхшээлтэй хүнд хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээ, хугацаа, үйлдлийн чадамж, хэрэгцээний үнэлгээнд үндэслэн, тэжээгч нь нас барсан 18 хүртэлх насны хүүхэдтэй өрхөд хүүхдийн тоо, өрхийн амьжиргааны түвшинтэй уялдуулан тус тус ялгаатай тогтооно.	9.2.Энэ хуулийн 7.1-д заасан хүнд олгох халамжийн тэтгэврийн хэмжээг ахмад настанд нийгмийн даатгалын шимтгэл төлж ажилласан жилтэй уялдуулан, тэжээгч нь нас барсан 18 хүртэлх насны хүүхэдтэй өрхөд хүүхдийн тоо, хөгжлийн бэрхшээлтэй хүнд олгох тэтгэврийн хэмжээг хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээ, хугацаа, үйлдлийн чадамж, хэрэгцээний үнэлгээнд үндэслэн тус тус ялгаатай тогтооно гэж өөрчлөх	Саналыг хэсэгчлэн тусгасан. “9.1.Энэ хуулийн 7.1-д заасан хүнд олгох амьжиргааг дэмжих тэтгэмжийн хэмжээг ахмад настанд өрхийн амьжиргааны түвшинтэй уялдуулан, хөгжлийн бэрхшээлтэй хүнд хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээ, хугацаа, бие даан амьдрах чадамж, хэрэгцээний цогц үнэлгээнд үндэслэн, тэжээгч нь нас барсан 18 хүртэлх

			насны хүүхэдтэй өрхөд болон энэ хуулийн 7.1.5-д заасан эх, эцэгт хүүхдийн тоо, өрхийн амьжиргааны түвшинтэй тус тус уялдуулан Засгийн газар ялгаатай тогтооно.” гэж заасан.
13	9.3.Энэ хуулийн 8.1.1, 8.1.2, 8.1.3-т заасан иргэнд олгох халамжийн тэтгэмжийн хэмжээ нь өрхийн амьжиргааны түвшин, ахмад настны цогц үнэлгээ, хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээ, хугацаа, үйлдлийн чадамж, хэрэгцээний үнэлгээнд үндэслэн, энэ хуулийн 8.1.4, 8.1.5-д заасан халамжийн тэтгэмжийн хэмжээ нь өрхийн амьжиргааны түвшин, хүүхдийн тооноос хамаарч тус тус ялгаатай байна.	хасах	Тусгах шаардлагагүй санал.
14	10.3.16 хүртэлх насны хүүхдэд нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийг эцэг, эх, эсхүл хууль ёсны асран хамгаалагч, харгалзан дэмжигчид олгох бөгөөд хүүхэд 16 насанд хүрсэн хүүхэд хүсэлт гаргасан тохиолдолд өөрт нь олгоно. Хэрэв хүүхэд асрамжийн үйлчилгээнд хамрагдаж байгаа бол тухайн хүүхдийн арилжааны банк дахь дансанд шилжүүлнэ.	10.3.18 хүртэлх насны хүүхдэд нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийг эцэг, эх, эсхүл хууль ёсны асран хамгаалагч, харгалзан дэмжигчид олгох бөгөөд 16 насанд хүрсэн хүүхэд хүсэлт гаргасан тохиолдолд өөрт нь олгож болно. Хэрэв хүүхэд асрамжийн үйлчилгээнд хамрагдаж байгаа бол тухайн хүүхдийн арилжааны банк дахь дансанд шилжүүлнэ.	Тусгах шаардлагагүй санал.
15	12.2.Өрхийн амьжиргааны түвшин нь босго шугамаас доогуур үнэлгээтэй өрх эсхүл байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй өрхөд нийтийн халаалтгүй сууц, гэрт амьдардаг бол жилд нэг удаа хөнгөлөлттэй үнээр түлш олгох арга хэмжээг аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлаас баталсан журмын дагуу хэрэгжүүлж, орон нутгийн төсвөөс	Улсын төсвөөс санхүүжүүлэх.	Тусгах шаардлагагүй санал.

	санхүүжүүлнэ		
16	13.4.5.хүүхэд нь сургуулийн өмнөх боловсролд хамрагдаагүй бол 6 хүртэлх насны хүүхдээ асарч байгаа эх эсхүл эцэг;	Төр дааж байгаа тул хасах	Тусгах шаардлагагүй санал.
17	13.8. Сум, хорооны нийгмийн халамжийн мэргэжилтэн нь иргэний үнэмлэхгүй, шилжилт хөдөлгөөний бүртгэлгүй зорилтот өрх, иргэнийг илрүүлж, кейс менежментэд үндэслэн 6 хүртэлх сарын хугацаанд хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлж болно. Энэ хугацаанд улсын бүртгэлийн ажилтантай хамтран баримт бичгийн зөрчлийг арилган зохих нийгмийн халамжийн болон бусад арга хэмжээнд хамруулна.	Системийн орчинд судлах	Саналыг журамд нарийвчлан тусгана.
18	14.2.Боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас ирүүлсэн энэ хуулийн 14.1.1, 14.1.2-т заасан дэмжлэгт хамрагдах суралцагчийн мэдээлэлд үндэслэн дэмжлэгийг олгох арга хэмжээг зохион байгуулна.	Хөрөнгөөр ялгаварласан заалт тул хасах.	Саналыг тусгаж заалтыг өөрчлөн найруулсан. “14.2.Нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас ирүүлсэн суралцагчийн мэдээлэлд үндэслэн энэ хуулийн 14.1-д заасан дэмжлэгийг тухайн суралцагчийн арилжааны банк дахь харилцах дансанд нийгмийн халамжийн сангаас шилжүүлнэ.” гэж өөрчилсөн.
19	17.6.Гэр оронгүй, оршин суух тодорхой газаргүй өрх, иргэнийг илрүүлэх, түр хоноглох байранд байрлуулах, нийгмийн үйлчилгээнд холбон зуучлах, нийгэмшүүлэх, хөдөлмөрт бэлтгэх, гэр бүлд нь эргэн нэгтгэх үйлчилгээг энэ хуулийн 16.2-т заасныд дагуу сонгон	газаргүй гэдэг үгийг хаяггүй гэж өөрчлөх	Саналыг тусгаж заалтыг өөрчлөн найруулсан. Гэр оронгүй, оршин суух тодорхой газаргүй өрх, иргэн гэдгийг “орон гэргүй тэнэмэл амьдралтай өрх, иргэн” гэж өөрчилсөн.

	шалгаруулж, гэрээлэн гүйцэтгүүлнэ.		
20	18.2.4 Хүүхэд хамгааллын тухай хуулийн 4.1.4-т заасан эрслэлт нөхцөлд байгаа хүүхэд 18.7 нийгмийн халамжийн сангаас санхүүжүүлнэ.	Хүүхдийн төрөлжсөн асрамжийн хувьсах болон үйлчилгээний зардлыг магадлан итгэмжлэл олгож байгаа байгууллага олгох нь зүйтэй.	Саналыг тусгасан. Хуулийн төслийн 19.8 дахь хэсэгт “Энэ хуулийн 19.2.4-т заасан хүүхдэд асрамжийн үйлчилгээ үзүүлж байгаа иргэн, хуулийн этгээд нь хувьсах зардлыг хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан журмын дагуу хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагатай гэрээ байгуулан хүүхэд хамгааллын санхүүжилтээс авч болно.” Гэж тусгасан.
21	19.2.1.эрсдэлийн үнэлгээг хийж, гэнэтийн аюулт үзэгдэл, эрсдэлт нөхцөл байдалд өртөж болзошгүй өрх, иргэнийг тодорхойлох, хэрэгцээг үнэлэх, хамрагдах боломжтой үйлчилгээний мэдээллийг гаргах цогц мэдээллийн эрт анхааруулах системийг ажиллуулах;	Хасах	Саналыг тусгаж заалтыг өөрчлөн найруулсан. 20.3.1.эрсдэлийн үнэлгээг хийж, гэнэтийн аюулт үзэгдэл, эрсдэлт нөхцөл байдалд өртөж болзошгүй өрх, иргэнийг тодорхойлох, эрсдэл бүхий өрхүүдийн мэдээллийг онцгой байдлын байгууллагатай хуваалцаж, хамрагдах боломжтой үйлчилгээний мэдээллийг гаргаж, эрт сэрэмжлүүлэх арга хэмжээ авах;
22	19.2.2.энэ хуулийн 19.2.1-д заасан эрт анхааруулах системийн хүрээнд эрсдэлийн зэрэг өндөртэй нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай болон зорилтот өрх, иргэнд	Энэ хуулийн 19.2.1-д заасан эрт анхааруулах системийн хүрээнд хасах.	Саналыг тусгаж заалтыг өөрчлөн найруулсан. 20.3.3.энэ хуулийн 20.3.1-д заасан эрт сэрэмжлүүлэх арга хэмжээний хүрээнд эрсдэлийн

	нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, хүүхдийн мөнгөн тэтгэмжийг 3 хүртэлх сарын хугацаагаар урьдчилан олгох;		зэрэг өндөр гэж тодорхойлогдсон орон нутгийн Гамшгаас хамгаалах тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2-т заасан Гамшгийн эрсдэлийг бууруулах орон нутгийн зөвлөлийн шийдвэрийг үндэслэн зорилтот өрх, иргэнд нийгмийн халамжийн тэтгэмж, хүүхдийн мөнгөн дэмжлэгийг иргэний хүсэлтэд үндэслэн гурав хүртэлх сарын хугацаагаар урьдчилан олгох;
23	19.2.4.гамшиг, аюулт үзэгдлээс урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах, үйл ажиллагааг төлөвлөх, орон нутгийн өрх иргэдэд сургалт, сурталчилгаа зохион байгуулах, мэдээллээр хангах ажлыг хариуцан хэрэгжүүлэх.	Хасах	Саналыг тусгаж заалтыг өөрчлөн найруулсан.
24	19.3.2.энэ хуулийн 19.3.1-д заасан халамжийн тэтгэвэр, тэтгэмж, дэмжлэгт хамрагддаггүй өрх бол тухайн бүсийн амьжиргааны доод түвшинтэй тэнцэх хэмжээний тэтгэмжийг 6 хүртэлх сарын хугацаанд олгох;	Хасах	Саналыг тусгаж, заалтыг хассан.
25	19.3.4. Гэр бүлийн хөгжлийг дэмжих төвөөс сэтгэл зүйн болон холбогдох зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах;	Хасах	Тусгах шаардлагагүй санал. Энэ үйлчилгээ нь гамшигт нэрвэгдсэн өрх, иргэнд зайлшгүй шаардлагатай үйлчилгээ юм.
26	22.1.5.Шинэ төрлийн үйлчилгээ турших болон хууль тогтоомжийн өөрчлөлтийн улмаас нийгмийн халамжаас хасагдсан иргэнд үзүүлэх үйлчилгээний;	Хасах	Тусгах шаардлагагүй санал. Одоогийн хүчин төгөлдөр мөрдөж байгаа хуульд мөн туссан санал юм.
27	22.1.9.Нийгмийн халамжийн бодлого, үр нөлөө, үйл ажиллагаанд судалгаа,	22.1.9.нийгмийн халамжийн бодлого, үр нөлөө, үйл ажиллагаанд	Тусгах шаардлагагүй санал. Одоогийн хүчин төгөлдөр

	шинжилгээ, хяналт, үнэлгээ хийх;	судалгаа, шинжилгээ, хяналт, үнэлгээ, нөхцөл байдлын үнэлгээ хийх;	мөрдөж байгаа хуульд мөн туссан санал юм.
28	24.1 Нийгмийн халамжийн үйл ажиллагааг улсын хэмжээнд нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, орон нутагт тухайн шатны Засаг дарга эрх хэмжээний хүрээнд удирдан зохион байгуулна.	/"удирдан зохион байгуулах" гэдгийг "эрх хэмжээний хүрээнд эрхэлнэ" гэж өөрчилнө.	Саналыг тусгасан. "24.1.Нийгмийн халамжийн үйл ажиллагааг улсын хэмжээнд нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, орон нутагт тухайн шатны Засаг дарга эрх хэмжээнийхээ хүрээнд эрхэлнэ." гэж өөрчилсөн.
29	25.1.Нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллагын тогтолцоо нь нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, аймаг, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага, нийгмийн халамжийн улсын байцаагч, сум, хорооны нийгмийн халамжийн мэргэжилтнээс бүрдэнэ.	... нийгмийн халамжийн улсын байцаагч бүрдэнэ гэж өөрчлөх	Саналыг тусгаж, нийгмийн халамжийн улсын байцаагч гэж нэмсэн.
30	27.4.Аймаг, дүүргийн Засаг дарга нь тухайн аймаг, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллагын даргыг нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын даргатай зөвшилцөн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллагад гурваас доошгүй жил ажилласан төрийн албан хаагчдаас Төрийн албаны тухай хуульд заасны дагуу сонгон шалгаруулж томилж, чөлөөлнө.	Хуучин халамжийн хуульд зааснаар оруулах	Саналыг тусгасан. Одоогийн хуулийн зохицуулалтыг хэвээр үлдээсэн.
31	29.1 Нийгмийн ажлын мэргэжлээр дээд боловсрол эзэмшсэн иргэнийг сум, хорооны нийгмийн халамжийн	Шалгуурыг өөрчлөх	Саналыг тусгасан. Нийгмийн халамжийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын

	мэргэжилтнээр ажиллуулна.		тухай хуульд 2028 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс өмнө сум, хорооны халамжийн нийгмийн ажилтнаар ажиллаж байсан төрийн захиргааны албан хаагчид энэ хуулийн 29.1 дэх хэсгийн Нийгмийн ажлын мэргэжлээр дээд боловсрол эзэмшсэн байх гэсэн нөхцөл хамаарахгүй байхаар тусгасан.
32	29.3.Сумын Засаг дарга нь сум, дүүргийн нийгмийн халамжийн мэргэжилтнийг тухайн аймгийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллагын дарга /зөвшилцөн, дүүргийн Засаг дарга нь хорооны нийгмийн халамжийн мэргэжилтнийг тухайн дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллагын даргатай зөвшилцөн Төрийн албаны тухай хуульд заасны дагуу томилж, чөлөөлнө.	Хуучин халамжийн хуульд зааснаар оруулах	Саналыг тусгасан. Одоогийн хуулийн зохицуулалтыг хэвээр үлдээсэн.
33	30.5. Нийгмийн халамжийн улсын байцаагч нь нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага эсхүл аймаг, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллагад 5-аас доошгүй жил ажилласан, ёс зүйн зөрчил гаргаагүй, нийгмийн халамжийн улсын байцаагчийн эрх олгох шалгалтад тэнцсэн байна.	5-аас доошгүй жил ажилласан, ёс зүйн зөрчил гаргаагүй гэсэн шалгуур орон нутагт өндөр байна.	Тусгах шаардлагагүй санал. Нийгмийн халамжийн улсын байцаагч нь мэргэшил, ёс зүйн хувьд зохих шаардлагыг хангасан байхаар хуулийн төсөлд тусгасан.
34	Нэмэх	Хуучин хуулийн заалтыг хэвээр үлдээх. 29 дүгээр зүйл. Амьжиргааг дэмжих зөвлөл	Тусгах шаардлагагүй санал.

35	Нэмэх	32.4. Аймаг, дүүрэг, сум, хороо, баг, тосгон дахь нийгмийн халамжийн мэргэжилтэнд эхний тав дахь жил болон дараагийн гурав дахь жил тутамд нэг удаа зургаан сарын үндсэн цалинтай нь тэнцэх хэмжээний мөнгөн тэтгэмжийг улсын төсвөөс олгох;	Тусгах шаардлагагүй санал. Төрийн албаны тухай хуулиар зохицуулна.
36	Нэмэх	32.5. Аймаг, дүүрэг, сум, хороо, баг, тосгон дахь нийгмийн халамжийн мэргэжилтэнд өндөр насны тэтгэвэр тогтоолгоход Төрийн албаны тухай хуульд заасны дагуу нэг удаагийн буцалтгүй тусламж олгох;	Тусгах шаардлагагүй санал. Төрийн албаны тухай хуулиар зохицуулах тул давхардуулан заах шаардлагагүй.

---oOo---

**НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫНТӨСЛИЙГ ХЭЛЭЛЦҮҮЛЭХ ҮЕД
АЖЛЫН ХЭСГИЙН ГИШҮҮД, ТӨРИЙН БОЛОН ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГА, ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗАР,
ХЭЛТСҮҮД, БУСАД БАЙГУУЛЛАГААС ИРҮҮЛСЭН САНАЛЫГ ТУСГАСАН БАЙДАЛ**

2023 оны 05 дугаар сарын 20

№	Байгууллага, иргэний нэр	Саналын товч утга	Саналыг тусгасан байдал
1.	Хөгжлийн бэрхшээлтэй иргэд байгууллагуудын шүхэр нэгдсэн бодлогын ерөнхий зөвлөл	<p>1.Нийгмийн халамжийн дэмжлэгийн хэсгийг тодорхой болгож хугацаа тавьж өгөх</p> <p>2.Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын халамжийн чиглэлээр хүлээх чиг үүргийг тодорхой заах</p> <p>3.Нийгмийн ажилтан нь халамжид байгаа хүнтэй ойр ажиллаж, үр дүн гаргах нөхцлийг бий болгох, сум, хороонд нийгмийн ажилтнаар ажилласан 3 жил тутамд урамшуулал олгохоор заах</p>	<p>1.Хуулийн төслийн “Нийгмийн халамжийн дэмжлэг” гэсэн 3 дугаар бүлэгт хүнс тэжээлийн дэмжлэг, боловсрол эзэмших дэмжлэг, эрүүл мэндийн дэмжлэг гэсэн 3 төрөлтэй байна. Нэг өрхийн хамрагдах хугацааг 24 сар байхаар зааж, 14.6.1.хөдөлмөрийн насны хөдөлмөрийн чадвартай иргэн нь хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хууль тогтоомжид заасан арга хэмжээ, үйлчилгээнд хамрагдах, хүүхдээ товллын дагуу заавал хийх дархлаажуулалтад бүрэн хамруулах, сургуулийн насны хүүхдээ албан эсхүл албан бус боловсролд бүрэн хамруулж, хүүхдэд суурь боловсрол эзэмшүүлэх нөхцлийг биелүүлэхээр заасан. Энэ нөхцлийг хэр биелүүлснээс шалтгаалж сунгах эсэхийг шийдвэрлэхээр заасан.</p> <p>Сурагчийн дүрэмт хувцасны үнийн хөнгөлөлт тусламжийг зорилтот бүлэгт чиглүүлэх үүднээс өрхийн амьжиргааны түвшинтэй уялдуулан 2 жилд нэг удаа олгохоор заасан.</p> <p>2.Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд заасан нийгмийн халамжийн хөнгөлөлт, тусламжийг олгоход</p> <p>3.Нийгмийн халамжийн цахимжуулалттай холбогдуулан нийгмийн ажилтны ажлын ачаалал багасах тул халамж шаардлагатай зорилтот өрх, иргэнд зөвлөгөө мэдээлэл өгөх, өрхөөр нь явж газар дээр нь нөхцөл байдлын үнэлгээ хийх,</p>

		<p>4.Амьжиргааг дэмжих зөвлөлийн ажлын чиг үүргийг нарийвчлан заах мөн хариуцлагын тогтолцоог бий болгох</p> <p>5.Нийгмийн ажилтан амьжиргааг дэмжих зөвлөлийн гишүүдийн хараат бус байдлыг хангах</p> <p>6.Халамжийн үйлчилгээний төсвийг нэмэх</p>	<p>дэмжих, төрийн бусад үйлчилгээнд холбон зуучлах зэрэг нийгмийн ажлын мэргэжлийн үйлчилгээг үзүүлэх нөхцлийг бүрдүүлсэн. Нийгмийн халамжийн үйлчилгээний шинэ төрлүүдийг зорилтот өрх, иргэдэд үзүүлэх нийгмийн ажилтны ажлын онцлог, эрсдэлт нөхцөлийг харгалзан нийгмийн ажилтнуудын нийгмийн баталгааг салбарын хууль эрх зүйн хүрээнд тусгах нь зүйтэй гэж үзэн сар бүрийн үр дүнгийн урамшуулал олгохоор хуулийн төсөлд тусгасан.</p> <p>4.Саналыг тусгав. Хуулийн төслийн 44.4 дэх хэсэгт нэмж тусгав. Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг нэмж боловсруулж хариуцлага хүлээлгэх зохицуулалтыг тусгасан.</p> <p>5.Саналыг тусгав.</p> <p>6. Нийгмийн халамжийн үйлчилгээнд зарцуулах зардлын хэмжээг халамжийн сангийн нийт зардлын 10 хувиас багагүй байхаар хуулийн төсөлд тусгасан.</p>
2	“Түгээмэл хөгжил төв” бие даан амьдрах төв	<p>Нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн 19 дүгээр зүйлд дараах байдлаар нэмэлт оруулах саналтай байна.</p> <p>19 дүгээр зүйл.Нийгмийн халамжийн дэмжлэг тусалцаа зайлшгүй шаардлагатай өрх, иргэний амьжиргааг дэмжих урт хугацааны үйлчилгээ</p> <p>19.2 дахь хэсэгт хөгжлийн бэрхшээлтэй хүний оршин суугаа орон байрны тохируулга, хүртээмжийг нэмэгдүүлэх тухай тусгаж өгөх саналтай байна. Учир нь Монгол Улсын өнөөгийн нөхцөлд орон сууц болон гэр хороололд амьдарч буй хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс гэр дотроо чөлөөтэй явах, ариун цэврийн өрөөнд орж чадахгүй байх зэрэг олон асуудал тулгарч эрх нь зөрчигддөг.</p> <p>Иймд хөгжлийн бэрхшээлийн хүндрэл хэлбэрээс нь шалтгаалан оршин суугаа газраа эрүүл аюулгүй, өөрийнхөө</p>	<p>Нийгмийн халамжийн тухай хуулийн төслийн 19 дүгээр зүйлд заасан үйлчилгээ нь ядуу, эмзэг бүлгийн өрх, иргэнийг чадавхижуулахад чиглэсэн, тэдний онцлог /Боловсрол бага, ажилгүй, ур чадвар муутай, амьдрах итгэл үнэмшил сул, бусдаас хамааралтай халамж хүртэгч, нийгмээс тусгаарлагдсан, санхүүгийн хувьд сул, өмч хөрөнгөгүй, түүнээс хүртэх үр өгөөж багатай г.м/ т нийцүүлж хэрэгжүүлэх үйлчилгээ юм.</p> <p>Иймд Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн төсөлд тусгуулахаар ажлын хэсэгт саналыг уламжилсан.</p>

		<p>хөгжлийн бэрхшээлийн онцлог, хэрэгцээ шаардлагад тохирсон орчин нөхцөлд амьдрах боломжийг нэмэгдүүлэхээр доорх агуулга бүхий нэмэлт зүйл заалт оруулах саналтай байна.</p> <p>19.2.8.хөгжлийн бэрхшээлтэй хүний оршин суугаа орон байрны тохируулга, хүртээмжийг сайжруулах зорилгоор нэг удаагийн дэмжлэг үзүүлэх</p> <p>19.4.Энэ хуулийн 19.2.8-д заасан зүйлийг хэрэгжүүлэхдээ Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага зохион байгуулна.</p>	
3	Хараагүйчүүдийн хөдөлмөр сургалтын төв	<p>Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд өгч байгаа ач холбогдол багатай хөтөлбөр байгаа, харилцаа холбооны зардлыг хасахгүйгээр харин орчин үеийн цахим технологит нийцүүлэн хүргэх хэлбэрийг оновчтой болгох нь зүйтэй.</p> <p>Асаргааны тэтгэмжийг яг шаардлагатай хэсэгт чиглүүлэх, бараг л өвчтэй хүн бүр авч байна, хяналтыг сайжруулах Цаашдаа халамжийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хувьд хавсарсан бэрхшээлтэй хэсэгт чиглүүлж, бусад хэсгийг хөдөлмөрөөр шахах, дэмжсэн шиг дэмжих хэрэгтэй байна.</p>	<p>1.Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд иргэний тэтгэвэрийг бодлогоор бусад тэтгэврээс хэмжээ нь илүү байхаар хуулийн төсөлд тусгасан. Ижил нэр төрлийн хэмжээ багатай, давтамж ижил олон хөтөлбөр байгааг иргэн болон халамжийн байгууллага, ажилтанд ойлгомжтой, хэрэгжүүлэхэд дөхөм байх /тус бүрд нь баримт материал бүрдүүлэх, олон материалыг хувийн хэрэгт бүрдүүлж, архивлах г.м/ зорилгоор харилцаа холбооны зардлыг нэгтгэсэн.</p> <p>2.Асаргааны тэтгэмж, тусламжийг нэгтгэж, асарч байгаа иргэний үүрэг, хариуцлагыг нэмэгдүүлсэн. Мөн халамжийн улсын байцаагчтай байх, мөн асаргаа шаардлагатай эсэхийг буруу тогтоосон тохиолдолд хариуцлагын заалтуудыг Нийгмийн халамжийн тухай хуулийн төсөлд болон Зөрчлийн тухай хуульд тусгайлан заалт оруулсан болно.</p> <p>Хөдөлмөр эрхлэх боломжтой хөдөлмөрийн насны халамж хүртэгч иргэнийг нийгмийн халамжийн үйлчилгээгээр дамжуулан хөдөлмөр эрхлэх боломжийг нэмэгдүүлсэн бөгөөд цаашлаад хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээнд хамрагдаж тохирсон ажи хөдөлмөр эрхлэх, орлогоо нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлсэн.</p>
4	Д.Баатаржав	1.Хүнсний талон хэн авахыг Засаг даргын зөвлөл шийддэг, дэвтрийг нь хурааж авдаг асуудал хөдөө орон нутагт байна.	Нийгмийн халамжид хамрагдах талаар сум, хорооны АМД зөвлөл үүрэгтэй байдаг бөгөөд

	Монголын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нэгдсэн холбоо	<p>2.ХБХХГ-ын дэргэд эмнэлэг юм уу байлгаад протез, ортопедийн хэрэгсэл олгох эсэхийг шийддэг байх болох эсэхийг судлах, орон нутагт эрх нь байхаар үзэмжээр танил талаар шийдээд байна.</p> <p>3.Алдар цолны нэмэгдэл сар бүр байвал амьжиргаанд нэмэртэй.</p>	<p>одоогийн хуулиар АДЗ-ийн гишүүдийг ИТХ-аас сонгож байгаа улс төр, намын харьяаллын хүнийг томилох, түүнээс улбаалаад орон нутагт халамжийг улс төржүүлэх асуудал гарч байна. Тиймээс хуулийн төсөлд АДЗ-ийн гишүүдийг орон нутгийн ЗД-тай зөвшилцөн аймаг, дүүргийн нийгмийн халамжийн байгууллагын дарга сонгохоор тусгасан.</p> <p>2.Протез, ортопедийн хэрэгслийн шаардлагатай эсэхийг сум, аймаг, дүүргийн түвшинд мэргэжлийн түвшинд шийдвэрлэдэг одоогийн тогтолцоо нь иргэндээ ойр, чирэгдэлгүй байгаа юм.</p> <p>3.Алдар цолны нэмэгдлийг сар бүр олгох давтамж хэвээр үргэлжилнэ.</p>
5	Эрхэм чанар ТББ	<p>1.Одоо байгаа олон нэр төрлийг цөөлөх, тусгай хэрэгслийг хасахгүй байх</p> <p>2.Протез ЭМД-ын санд шилжүүлэх нь зөв, тэгсэн тохиолдолд анхан шатанд материал бүрдүүлэх ажлыг хэн зохион байгуулахыг тодорхой болгох</p> <p>3.Халамжийн анхан шатны ажилтнуудыг энэ чиглэлээр чадавхижуулах, энэ талаар мэдлэг муу байдаг.</p>	<p>1.Одоо байгаа 80 гаруй төрлийг жагсаалтыг ЗГ-ын тогтоолыг шинэчлэн шаардлагагүй хэсгийг хасч цөөлөх боломжтой.</p> <p>2.Төрийн үйлчилгээ бүх түвшиндээ цахимжаж байгаа энэ үед иргэнээс баримт бичиг шаардахгүйгээр мэдээллийн нэгдсэн цахим системээс иргэнтэй холбоотой баримт бичгийг татан бүрдүүлэх, төрийн байгууллага хооронд мэдээллийг солилцох боломжтой юм.</p> <p>3.Халамжийн байгууллага хяналт тавих мэргэжил арга зүй байхгүй</p>
6	Монголын ахмадын чөлөөт холбоо Г.Баасан	<p>Хүн амын өсөлтийг дэмжих тухай хуулийн төсөл боловсруулан Нийгмийн халамжийн тухай хуульд шинэчилсэн найруулга хийхээр ажиллаж байгаад талархаж байна.</p> <p>Хүн амыг өсөлтийг дэмжих тухай хуулийн төсөлд манай байгууллагаас доорх саналуудыг хүргүүлж байна. Үүнд:</p> <p>1. Хуулийн төслийн 5 дугаар зүйлийн 5.1-д төрөөс олгох тэтгэмжийн төрөлд 5.1.4 Бүтэн болон хагас өнчин хүүхдийн тэтгэмж, 5.3-д Олон хүүхэдтэй гэр бүлд үзүүлэх хөнгөлөлтийн төрөлд 5.3.3 ажлын байрны хөнгөлөлт, 6</p>	<p>1.Нийгмийн халамжийн тухай хуулийн төсөлд тэжээгч нь нас барсан бүтэн болон хагас өнчин хүүхдэд халамжийн тэтгэвэр өгөхөөр тусгасан бөгөөд тухайн өрхөд байгаа хүүхдийн тооноос хамаарч тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэхээр</p>

		<p>дугаар зүйлийн тэтгэмж, шагнал, урамшуулал, хөнгөлөлт олгохтой холбогдсон харилцаанд Бүтэн болон хагас өнчин хүүхдийн тэтгэмж олгохыг нэмж оруулах санал гаргаж байна.</p> <p>2.Мөн хуулийн төсөлд дараах саналуудыг сайтар нягтлах саналыг дэвшүүлж байна. Үүнд: -Хэрэгжиж буй хуулийн 4-өөс дээш хүүхэдтэй өрхүүд хамрагдаж байгаа. Хүн амын өсөлтийг дэмжих гэсэн шинэ зорилт дэвшүүлэн хууль санаачилж байгаа тул 6 дугаар зүйлийн 6.6-д заасан дөрөв ба түүнээс дээш хүүхэдтэй гэсэн заалтыг гурав ба түүнээс дээш болгох /Эртнээс монголчууд нэг хүүхэдтэй өрхийг хүүхэдгүйд, хоёр хүүхэдтэй бол нэг хүүхэдтэйд, гурван хүүхэдтэй айлыг голомт үргэлжлүүлэх хүүхэдтэй айл гэж тооцож ирсэн нь нарийн учиртай байсныг судлах/, 3.6-д орон сууц зохицуулалтыг зөвхөн Засаг даргад хамаатуулсан нь хэт явцуу байх тул иргэдийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлыг нэмж оруулах, нэг хүний эрх мэдэл давамгайлах сөрөг эрсдэл үүсэхээс урьдчилан сэргийлэх, түрээслүүлэх, зээлд хамруулах, худалдан авах гэсэн зохицуулалтыг нарийвчлан оруулах, ялангуяа бага хүүтэй зээлд хамруулах, хөнгөлөлттэй нөхцөлөөр худалдан авах хоёрын ялгаа заагийг ойлгомжтой найруулах, 4.6.8-д давхардуулан олгохгүй гэсэн найруулгыг Нийгмийн даатгалын сангийн зохицуулалтыг тэтгэмж гэдэг ижил нэртэй учраас ялгааг ойлгомжтой найруулах, 5.6.11-д заасан хуримтлалын зохицуулалтын хяналтыг давхар хуульчлах, 6.13-д заасан аргачлалд олон нийтийн саналыг нээлттэй авч тусгах, 6.9 дүгээр зүйлийн 9.1-д хуурамч бичиг баримт бүрдүүлэх, илүү олгогдсон гэсэн тэтгэмж, урамшууллыг нөхөн төлүүлэх зохицуулалтыг шүүхийн шийдвэр, улсын байцаагчийн шийдвэр гарсан бол суутгал хийхээр заасан байна. Хэрэв илрээгүй илрүүлэхгүй, шийдвэр гарахгүй бол төсвийн хөрөнгө завших боломжийг эдлэхээр салаа утгатай байна.</p>	<p>тусгасан тул энэ хуульд тусгах шаардлагагүй болно.</p> <p>2.Хуулийн төслийн 6.6-д заасан хүүхдийн тоог 3 ба түүнээс дээш болгож саналыг тусгав.</p> <p>3.Саналыг тусгав.</p> <p>4.Ижил төрлийн тэтгэмж учраас Нийгмийн даатгалын сангаас гэж тодотгож тусгасан болно.</p> <p>5.Хүүхдийн мөнгөн тэтгэмжийг Ирээдүйн өв сангийн тухай хуулиар зохицуулахаар Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулийн төсөлд тусгасан тул уг хуулийн төслөөс хассан.</p> <p>6.Шүүхийн болон мэргэжлийн байгууллага, ажилтны хяналт шалгалтын дагуу гарсан шийдвэрийг үндэслэж суутгал хийх бөгөөд албан ёсны шийдвэр гараагүй байхад иргэний тэтгэмжээс суутгал хийхгүй гэдгийг эдгээр заалтад тодорхойлж өгсөн.</p>
--	--	--	---

		<p>9.3-д бусад тохиолдолд гэсэн нь нууцлаг юуг ч хамруулж болохоор цоорхой байна.</p> <p>7.10 дугаар зүйлийн 10.1-д энэ хуулийг зөрчсөн бол зөрчлийн хуулийн аль заалтаар хариуцлага хүлээлгэх, гэмт хэрэг үйлдсэн бол эрүүгийн хуулийн аль заалтуудын дагуу хариуцлага хүлээлгэхийг тодорхой зааж оруулахыг тус тус санал болгож байна.</p>	<p>7.Тухайн зөрчлөөс шалтгаалж дээх хуулийн аль зүйл заалтаар хариуцлага хүлээлгэхийг шийтгэл оногдуулж байгаа байгууллага, ажилтан шийдвэртээ тусгах учраас тухайлан заах боломжгүй юм.</p>
7	Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар Ч.Ганболд	<p>1.Хуулийн төсөл сайн хийгдсэн байна, батлагдах хүртэл сайн хамгаалах талд анхаарах, Хүнсний эрхийн бичиг олголтын төсөв их нэмэгдсэн, үүнтэй холбоотойгоор ажил хийдэг хүн байхгүй боллоо, ажил голоод хийхгүй байна. Тиймээс хөдөлмөрийн насны хүнийг хасах саналтай байна.</p>	<p>Хөдөлмөрийн насны иргэнийг хасаагүй бөгөөд харин хөдөлмөрийн эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, арга хэмжээнд хамрагдах нөхцөл шалгуур тавьж, биелүүлсэн эсэхээс хамаарч хөтөлбөрөөс хасах зохицуулалтыг хуулийн төсөлд тусгасан.</p>
8	МУБИС-ийн багш М.Нямдорж Улаанбаатар Их сургуулийн багш Б.Сүх-очир	<p>1.Нийгмийн ажилтан-мэргэжилтэн гэдэг томъёоллоор тусгах</p> <p>2.Төрийн болон ТББ-ын оролцоо, түүний хоорондын уялдаа үе шатыг нарийн зааж өгөх</p>	<p>1.Төслийн 41 дүгээр зүйлд мэргэжилтэн гэсэн томъёоллоор тусгасан.</p> <p>2.Нийгмийн халамжийн үйлчилгээг мэргэжлийн ТББ-аар гүйцэтгүүлэхээр тусгасан бөгөөд орон нутагт байгаа төрийн бус байгууллагуудыг нийгмийн халамжийн үйлчилгээг хамтран хэрэгжүүлэх чиглэлээр сургаж чадавхижуулах, мэргэжил, арга зүйгээр хангах замаар орон нутагт хэрэгжүүлэх халамжийн үйлчилгээний чанар, үр дүнг сайжруулан, хэрэгжүүлэх зохицуулалтыг хуулийн төсөлд тусгасан.</p>
9	АХБ-ны зөвлөх, МУИС-ийн багш Б.Энхцэцэг	<p>Олон улсад асаргааны чиглэлээр туршлага болж байгаа сайн хөтөлбөр гэдэг учраас асаргааны тэтгэмж, тусламжийг нэгтгэхгүй байх</p>	<p>Ижил нэр төрлийн олон хөтөлбөр байгааг иргэн болон халамжийн байгууллага, ажилтанд ойлгомжтой, хэрэгжүүлэхэд дөхөм байх /тус бүрд нь баримт материал бүрдүүлэх, олон материалыг хувийн хэрэгт бүрдүүлж, архивлах г.м/ зорилгоор асаргааны тэтгэмж, тусламжийг нэгтгэсэн. Нэгтгэсэн боловч асарч байгаа иргэн болон асруулагч нарын одоогийн нөхцөл дордохгүй, тэтгэмжийн хэмжээ буурахгүй, халамжийн байгууллага асрагч иргэнтэй гэрээ байгуулж, асаргааны ур чадвар олгох сургалтанд хамруулах, чанар үр дүнд хяналт тавих одоогийн тогтолцоо хэвээр байх юм.</p>

10	МУИС-ийн Г.Түмэннаст багш	<p>1.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээг энэ хуульд авчирч наах биш уялдуулах</p> <p>2.Олон улсад нөхцөлт мөнгөн тэтгэмж зан үйл, эрүүл мэнд, боловсролтой уялддаг, хуулийн төсөлд эрүүл мэнд, боловсролтой уялдуулах зохицуулалт туссан байна. Зан үйл, хэрэгцээтэй уялдуулах</p> <p>ОНОТХҮ-г орон нутгийн оролцоонд түшиглэсэн байдлаар хэрэгжүүлдэг олон улсын жишгээр төсөлд оруулж ирж байгаа нь дэвшилттэй болсон байна.</p>	<p>1.Саналыг холбогдох хэсэг, заалтуудад тусгасан.</p> <p>2.Нийгмийн халамжийн дэмжлэг болон зорилтот өрх, иргэний хөгжлийг дэмжих үйлчилгээнд хамрагдсан өрх, иргэнд эрүүл мэнд, боловсролын шалгуур нөхцөл тавсан. Мөн түүнчлэн зорилтот өрх, иргэний хөгжлийг дэмжих үйлчилгээг мэргэжлийн төрийн бус байгууллага тухайн өрх, иргэнтэй хамтран боловсруулсан хөгжлийн төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлэх бөгөөд тухайн өрх, иргэн идэвх оролцоо, тухайн өрхийн цаашдын хэрэгцээнд тулгуурлан дараагийн шатны хөтөлбөр, арга хэмжээнд холбон зуучлахаар хуулийн төсөлд тусгасан. Энэ үйлчилгээг хэрэгжүүлэхэд орон нутгийн байгууллагын хамтын оролцоотойгоор хэрэгжүүлнэ.</p>
11	СХД, ХХҮХ Б.Цовоо	Иргэний үүрэгтэй холбоотой зохицуулалт хуулийн төсөлд тусгах шаардлагатай байна. Тэтгэвэр, тэтгэмж авч байсан гэр бүлийн хүн нь нас барах тохиолдолд мэдэгдэхгүй илүү авах асуудал гардаг учраас үүрэгжүүлэх шаардлагатай байна.	Саналыг хуулийн төслийн 40.1 дэх хэсэгт нийгмийн халамжийн арга хэмжээнд хамрагдаж байгаа өрх, иргэний хүлээх үүргийг тусгалаа.
12	ХНХЯ, Н.Баярмаа ГББХЗГ-	НҮБ-ын Хүүхдийн Эрхийн хорооноос ирүүлсэн зөвлөмжийн дагуу төвлөрсөн асрамж халамжийн үйлчилгээнээс хүүхэд асрах хувилбарт үйлчилгээнд шилжүүлэх чиглэлийг баримталж байгаа. Тиймээс хүүхдийн асрамж гэдгийг Хүүхэд хамгааллын хуультай нийцүүлж томъёолох Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээний зардлыг гаргах зохицуулалт одоогийн хууль тогтоомжид байхгүй байгаа тул энэ хуульд нэмж тусгах	Хүүхэд хамгааллын хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг нэмж боловсруулж 13.6-д “Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээний хоол хүнс, хувцас, зөөлөн эдлэл, эм, ариун цэвэр, сургалтын хэрэглэгдэхүүний болон оршуулгын зардлын хэмжээг санхүү, төсвийн болон хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.” гэсэн заалт тусгав.
13.		<p>Хуулийн төслийн 3.2.1-3.2.6 бүхэлд нь хасах</p> <p>9.2.Тэтгэврийн даатгалын сангаас тэтгэвэр авах эрх үүсээгүй өндөр насны тэтгэвэр тогтоолгох насанд хүрсэн ахмад настны тэтгэврийн хэмжээ нь нийгмийн даатгалын сангаас олгох хувь тэнцүүлсэн тэтгэврийн доод хэмжээний 50 хувьтай тэнцүү байна гэсэн нь мөнгөн дүнгийн хэмжээ бага байгаа тул нэмэх</p>	<p>Саналыг тусгав.</p> <p>Энэ зүйл заалтын дагуу одоо нийгмийн халамжийн тэтгэвэр авах үүссэн болон авч байгаа ахмадуудын тэтгэврийн хэмжээ буурахгүй.</p> <p>Харин хууль хэрэгжсэнээс хойш шинээр эрх үүсэх иргэдэд хамаарах юм. Учир нь нийгмийн</p>

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар		халамжийн тэтгэвэр авагч ахмад настны тоо харьцангуй тогтвортой байгаа хэдий ч нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийг нэмэгдүүлэх бодлоготой уялдуулахгүй бол цаашид насжилттай холбоотойгоор халамжид хамрагдах ахмад настны тоо нэмэгдэх хандлагатай байна. Нийгмийн даатгалын тогтолцоогоор дамжуулан эдгээр иргэдийн нийгмийн даатгалд хамрагдалтыг нэмэгдүүлэх арга хэмжээ авч байгаа хэдий ч цаашдаа нийгмийн халамжийн бодлогыг уялдуулах нөгөө талаас нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийг нэмэгдүүлэх, шимтгэл төлсөн болон шимтгэл төлөөгүй иргэдийн тэтгэврийн хэмжээ ялгаатай байх шударга зарчмыг хангах үүднээс энэ заалтыг тусгасан.
	10 дугаар зүйл.Тэтгэвэр, тэтгэмж авах хүсэлт гаргах, шийдвэрлэх	Саналыг тусгав.
	10.3.Сум, хорооны нийгмийн ажилтан тэтгэвэр, тэтгэмж авах иргэний баримт бичиг, өргөдлийг хүлээж авснаас хойш ажлын 10 хүртэлх хоногийн дотор хянан шийдвэрлэнэ.	Нийгмийн халамжийн үйлчилгээг цахимжуулалттай холбоотой иргэний хүсэлтийг шийдвэрлэх хугацаа багасаж байгаа бөгөөд үйлчилгээний төрлөөс хамаарч 3-5 хоног шаардаж байгаа. Тиймээс хугацааг хуулийн төсөлд 10 хүртэлх гэж тусгасан болно.
	10.4.Тэтгэвэр, тэтгэмж авах иргэний өргөдөл, хувийн хэрэг болон бусад маягтын загварыг нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрснөөр төрийн захиргааны байгууллага батална.	Саналыг тусгав.
	11.3.18 хүртэлх насны хүүхдэд олгох тэтгэвэр, тэтгэмжийг эцэг, эх, эсхүл хууль ёсны асран хамгаалагч, харгалзан дэмжигчид, 14-өөс 18 хүртэлх насны хүүхэд хүсвэл өөрт нь олгоно.	Иргэний тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дахь хэсэгт “Насанд хүрээгүй буюу 14-өөс 18 хүртэлх насны этгээд иргэний эрх зүйн бүрэн бус чадамжтай байна” гэж заасан байх тул энэ заалтыг 14-18 хүртэлх гэснийг хассан болно.
	12.1.9.Монгол Улсын нийгмийн хамгааллын олон улсын хэлэлцээрт өөрөөр заагаагүй бол Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа тэтгэвэр, тэтгэмж авагч гадаадын иргэн, харьяалалгүй хүн Монгол Улсаас бүр мөсөн буцах хүсэлт гаргасан бол Монгол Улсын хилээр гарсан өдрөөс гэдэг дээр энэ мэдээллийг авах газар тодорхойгүй, иргэний хилээр гарсан өдрийн тухай бүр мэдэх боломжгүй.	Гадаадын иргэн харьяатын газар болон Хил хамгаалах ерөнхий газраас хилээр гарсан иргэний мэдээллийг солилцон авах боломжтой.

		<p>15 дугаар зүйл.Боловсрол эзэмшихэд үзүүлэх дэмжлэг Энэ бүлгийг бүхэлд нь Боловсролын тухай хуульд оруулах</p>	<p>Дэлхийн ихэнх улс орнууд ядуу, эмзэг бүлгийн өрх болон өрхийн гишүүн, хүүхдийн эрүүл мэнд, боловсролтой холбоотой дэмжлэгийг Нийгмийн халамж хамгааллын тухай хуулиар зохицуулдаг. Олон улсад нөхцөлт мөнгөн тэтгэмж, дэмжлэгийг ядуу өрхөд олгохдоо зан үйл, эрүүл мэнд, боловсролтой уялддаг бөгөөд одоогийн нийгмийн халамжийн хуульд ч энэ зохицуулалт хэрэгжиж байна. Тиймээс хасах боломжгүй юм.</p>
<p>16 дугаар зүйл.Эрүүл мэндийн дэмжлэг Энэ бүлгийг бүхэлд нь Эрүүл мэндийн тухай хуульд оруулах</p>			
<p>20 дугаар зүйл.Цочролын сөрөг нөлөөг бууруулах үйлчилгээ /энэ бүлгийг хөгжлийн үйлчилгээний бүлгээс хасах, өөр үйлчилгээний бүлэгт оруулах/ /цочрол гэдэг нэр томъёогоо дахин харах/</p>	<p>Нийгмийн халамжийн арга хэмжээг 1.нийгмийн халамжийн тэтгэвэр; 2.нийгмийн халамжийн тэтгэмж; 3.нийгмийн халамжийн дэмжлэг; 4.нийгмийн халамжийн үйлчилгээ гэсэн 4 төрөлтэй байхаар хуулийн төсөлд тусгасан бөгөөд үүний нийгмийн халамжийн үйлчилгээ гэсэн төрөлд тусгасан.</p>		
<p>23 дугаар зүйл.Олон нийтийн оролцоонд түшиглэсэн хөгжлийн үйлчилгээ /сэргээн засах үйлчилгээ, өдрийн үйлчилгээг хэвээр үлдээх/</p>	<p>Сэргээн засах үйлчилгээг Эрүүл мэндийн тухай хуулийн дагуу эрүүл мэндийн байгууллага хариуцдаг тул нэмэх боломжгүй. Өдрийн үйлчилгээг Ахмад настны тухай хуульд заасан өдрийн үйлчилгээний хүрээнд хэрэгжүүлэх боломжтой байгаа болно.</p>		
<p>35.3.Аймаг, нийслэл, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага нь хоёр хүртэлх тооны улсын байцаагчтай байна.</p>	<p>Саналыг тусгав.</p>		